

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2014 ОНЫ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮН МЭДЭЭ

НЭГ. ХУРААНГУЙ	2
1.1. Анхан шатны шүүх.....	2
1.2. Давж заалдах шатны шүүх.....	3
1.3. Хяналтын шатны шүүх.....	4
ХОЁР. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ	6
2.1. Анхан шатны шүүх.....	6
2.2. Давж заалдах шатны шүүх.....	14
2.3. Хяналтын шатны шүүх.....	17
ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРЭГ	19
3.1. Анхан шатны шүүх.....	19
3.2. Давж заалдах шатны шүүх.....	24
3.3. Хяналтын шатны шүүх.....	27
ДӨРӨВ. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ	29
4.1. Анхан шатны шүүх.....	29
4.2. Давж заалдах шатны шүүх.....	34
4.3. Хяналтын шатны шүүх.....	37
ТАВ. ШҮҮН ТАСЛАХ БУСАД АЖИЛЛАГАА	39
5.1. Сэжигтнийг баривчлах, арга хэмжээ.....	39
5.2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ	40
5.3. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн тухай	41
5.4. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн талаар.....	43
ЗУРГАА. ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА.....	45
ДОЛОО. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	47
НАЙМ. ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	48
8.1. Шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдал.....	50
8.2. Шүүгчийн хэргийн ачаалал.....	55

НЭГ. ХУРААНГУЙ

1.1. Анхан шатны шүүх

Анхан шатны шүүх 2014 онд эрүүгийн 6375 хэрэг, иргэний 33996 хэрэг, захиргааны 1187 хэрэг, нийт 41558 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, 18611 зөрчилд захиргааны хариуцлага оногдуулж, 1762 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах болон ялаас чөлөөлж, 3721 хүнд баривчлах, цагдан хорих арга хэмжээ авчээ. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргийн тоо өмнөх онтой харьцуулахад 1031 хэргээр буюу 2.4 хувиар буурсан бөгөөд үүнээс эрүүгийн хэрэг 3.3 хувиар, захиргааны хэрэг 7.3 хувиар тус тус өссөн бол иргэний хэрэг 3.7 хувиар буурчээ.

График 1.1





График 1.2




Эрүүгийн хэрэг: Анхан шатны шүүх 2014 онд нийт 11430 хүнд холбогдох 7603 эрүүгийн хэрэг хүлээн авч, 1430 хүнд холбогдох 712 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, 41 хүнд холбогдох 23 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, нийт 6375 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 8178 хүнд ял шийтгэл оногдуулсан бөгөөд тайлангийн эцсийн байдлаар 493 хэргийн үлдэгдэлтэй байна.

Иргэний хэрэг: Анхан шатны шүүх 2014 онд нийт 48431 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 8755 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, 33996 хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж, тайлангийн эцсийн байдлаар 5680 хэргийн үлдэгдэлтэй байна.

Захиргааны хэрэг: Анхан шатны шүүх 2014 онд нийт 2437 хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас 648 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 1187 хэргийг хянан шийдвэрлэж, тайлангийн эцсийн байдлаар 602 хэргийн үлдэгдэлтэй байна.

График 1.3




1.2. Давж заалдах шатны шүүх

Давж заалдах шатны шүүх 2014 онд эрүүгийн 2161, иргэний 1947, захиргааны 883 хэрэг, нийт 4991 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 10.3 хувиар, иргэний хэрэг 6 хувиар, захиргааны хэрэг 47.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

График 1.4



График 1.5



Эрүүгийн хэрэг: Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2014 онд нийт 2251 хэрэг хүлээн авч, 2161 хэргийг хянан шийдвэрлэж, 40 хэрэгт давж заалдах гомдлоосоо татгалзаж, 50 хэргийн үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн 1007 тогтоолыг хэвээр үлдээж, 477 тогтоолд өөрчлөлт оруулж, 677 тогтоолыг хүчингүй болгосон байна.

Иргэний хэрэг: Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2014 онд нийт 2116 хэрэг хүлээн авч, 46 хэрэгт давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 13 хэрэгт давж заалдах гомдлоосоо татгалзсан бол 1947 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 5 хэрэгт

арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэж, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас 10 шийдвэрийг дахин хянасан байна. Улсын хэмжээнд иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд жилийн эцэст 95 хэргийн үлдэгдэлтэй байна.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн 593 шийдвэрт өөрчлөлт оруулж, 742 шийдвэрийг хэвээр үлдээж 612 нэхэмжлэл, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Захиргааны хэрэг: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2014 онд нийт 933 хэрэг хүлээн авч, 883 хэргийг хянан шийдвэрлэснээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан бүгд 512, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан бүгд 343, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан бүгд 3, бусад хэрэг 25, тайлангийн үеийн эцсийн үлдэгдэл 50 хэрэг байна.

Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн нийт 512 хэргээс 283 буюу 55 хувьд шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 103 буюу 20 хувьд нь шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 126 буюу 25 хувьд нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож тус тус шийдвэрлэжээ.


1.3. Хяналтын шатны шүүх

Хяналтын шатны шүүх 2014 онд эрүүгийн 629, иргэний 1017, захиргааны 381, нийт 2027 хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 3.5 хувиар, захиргааны хэрэг 42.2 хувиар тус тус өссөн бол эрүүгийн хэрэг 8.2 хувиар буурчээ.

График 1.6



График 1.7



Эрүүгийн хэрэг: Улсын дээд шүүх 2014 онд хяналтын шатны журмаар нийт 648 хэрэг хүлээн авч, 52 хэргийг Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг шийдвэрлэж, шүүх хуралдаанаар 484 хэргийг хянан шийдвэрлэж, 93 хэргийг хянаад буцаасан бөгөөд тайлант хугацааны эцэст 19 хэргийн үлдэгдэлтэй байна. Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 484 хэргээс 426 хэргийг

гомдлын дагуу, 18 хэрэгт прокурорын эсэргүүцлээр, 40 хэрэгт прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн 484 хэргээс 276 тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 108 тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 100 тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.

Иргэний хэрэг: Улсын дээд шүүх 2014 онд нийт 1050 иргэний хэрэг хүлээн авснаас 1017 хэргийг шийдвэрлэжээ. Үүнээс 841 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэж, 139 хэргийг шүүх хуралдаанд оруулаагүй шийдвэрлэж, 37 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 33 хэргийн үлдэгдэлтэй байна.

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим нийт 841 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс 503 хэрэгт буюу 59.8 хувьд шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгосон бол 132 хэрэгт буюу 15.7 хувьд шийдвэр, магадлалыг өөрчилж, 89 хэрэгт буюу 10.6 хувьд зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, 117 хэрэгт буюу 13.9 хувьд нь шийдвэр, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Захиргааны хэрэг: Хяналтын шатны шүүх 2014 онд нийт 393 захиргааны хэрэг хүлээн авч, 381 хэргийг шийдвэрлэснээс 300 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 40 хэрэгт албан бичгээр хариу өгч, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан 27 хэргийг шийдвэрлэж, “хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын гомдлоосоо татгалзсан”, “хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрсэн буюу тооцох боломжгүй” үндэслэлээр нийт 14 хэргийг шүүх хуралдаанд оруулалгүйгээр шийдвэрлэж, тайлант хугацааны эцэст 12 хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим нийт 300 хэрэг шийдвэрлэсний 212 буюу 70.6 хувьд шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 34 буюу 11.33 хувьд шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 25 буюу 8.3 хувьд шийдвэр, магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, 9 хэрэгт буюу 3 хувьд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 20 буюу 6.6 хувьд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэжээ.

ХОЁР. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ**2.1. Анхан шатны шүүх**

Монгол Улсын шүүх 2014 онд нийт 11430 хүнд холбогдох 7603 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 1430 хүнд холбогдох 712 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, 41 хүнд холбогдох 23 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 219 хүнд холбогдох 72 хэргийг цагаатгах тогтоолоор, 747 хүнд холбогдох 468 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгож, нийт 6375 эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж, 8178 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 3.3 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 1.4 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Ял шийтгүүлсэн нийт 8178 хүний 718 буюу 8.7 хувь нь эмэгтэй, 467 буюу 5.7 хувь нь насанд хүрээгүй этгээд, 23.4 хувь буюу 1919 хүн урьд нь ял шийтгүүлж байсан, 19.3 хувь буюу 1582 хүн согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 5.5 хувь буюу 455 хүн гэмт хэрэг давтан үйлдсэн байна.

Хүснэгт 2.1

Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Ял шийтгүүлсэн хүний тоо	№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Ял шийтгүүлсэн хүний тоо
1	Сум дундын 1 дүгээр шүүх	151	229	18	Сум дундын 18 дугааршүүх	60	79
2	Сум дундын 2 дугаар шүүх	76	103	19	Сум дундын 19 дүгээршүүх	133	148
3	Сум дундын 3 дугаар шүүх	195	215	20	Сум дундын 20 дугааршүүх	134	186
4	Сум дундын 4 дүгээр шүүх	116	145	21	Сум дундын 21 дүгээршүүх	146	194
5	Сум дундын 5 дугаар шүүх	63	66	22	Сум дундын 22 дугааршүүх	69	73
6	Сум дундын 6 дугаар шүүх	46	53	23	Сум дундын 23 дугааршүүх	168	184
7	Сум дундын 7 дугаар шүүх	254	331	24	Сум дундын 24 дүгээршүүх	113	147
8	Сум дундын 8 дугаар шүүх	99	134	25	Сум дундын 25 дугааршүүх	62	86
9	Сум дундын 9 дүгээр шүүх	97	107	26	Сум дундын 26 дугааршүүх	15	20
10	Сум дундын 10 дугаар шүүх	221	304	27	Сум дундын 27 дугааршүүх	226	230
11	Сум дундын 11 дүгээр шүүх	88	109	28	Сум дундын 28 дугааршүүх	135	213
12	Сум дундын 12 дугаар шүүх	59	74	29	Сум дундын 29 дүгээршүүх	32	35
13	Сум дундын 13 дугаар шүүх	32	41	30	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	1344	1778
14	Сум дундын 14 дүгээр шүүх	220	270	31	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	1488	1952
15	Сум дундын 15 дугаар шүүх	84	106	32	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	108	131
16	Сум дундын 16 дугаар шүүх	89	127	33	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	138	173
17	Сум дундын 17 дугаар шүүх	114	135	-	Бүгд	6375	8178

Ял шийтгүүлэгчид: Шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийг зарим бүлгээр авч үзвэл урьд ял шийтгүүлсэн хүн 1919 буюу 23.4 хувийг, гэмт хэрэг давтан үйлдсэн хүн 455 буюу 5.5 хувийг, бүлэглэж үйлдсэн хүн 1604 буюу 19.6 хувийг, согтуугаар үйлдсэн хүн 1582 буюу 19.3 хувийг, эмэгтэйчүүд 718 буюу 8.7 хувийг, насанд хүрээгүй этгээд 467 буюу 5.7 хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулбал бүлэглэж гэмт хэрэг үйлдсэн болон урьд ял шийтгүүлж байсан хүний тоо өсөх хандлагатай байна. Ял шийтгүүлэгчдийн дотроос ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 26 хүн буюу 3.8 хувиар, бүлэглэж үйлдсэн гэмт хэрэг 190 хүн буюу 13.4 хувиар, урьд ял шийтгүүлсэн хүний тоо 221 хүн буюу 13 хувиар өссөн бол гэмт хэрэг давтан үйлдэж ял шийтгүүлсэн хүний тоо 49 хүнээр буюу 9.7 хувиар, согтуугаар гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүний тоо 128 хүнээр буюу 7.5 хувиар, насанд хүрээгүй этгээдийн тоо 98 хүнээр буюу 17.3 хувиар тус тус буурсан байна. /Хүснэгт 2.2/

Хүснэгт 2.2

Ял шийтгүүлэгчид зарим бүлгээр

№	Утга	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Урьд ял шийтгүүлсэн	1698	1919	221	13
2.	Гэмт хэрэг давтан үйлдсэн	504	455	-49	-9.7
3.	Бүлэглэж үйлдсэн	1414	1604	190	13.4
4.	Согтуугаар үйлдсэн	1710	1582	-128	-7.5
5.	Эмэгтэй	692	718	26	3.8
6.	Насанд хүрээгүй этгээд	565	467	-98	-17.3

Шийдвэрлэсэн хэргийн төрөл: Өнгөрсөн онтой харьцуулбал анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хүнийг санаатай алах гэмт хэрэг 1.9 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10.8 хувиар, танхайрах гэмт хэрэг 13.5 хувиар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 15.5 хувиар буурсан бол бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 20.7 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 12.0 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 20.7 хувиар тус тус өссөн байна. /Хүснэгт 2.3/

Хүснэгт 2.3

Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн Тоо			
		Он		Өсөлт, Бууралт		Он		Өсөлт, Бууралт	
		2013	2014	Тоо	Хувь	2013	2014	Тоо	Хувь
1.	Хүнийг санаатай алах	203	199	-4	-1.9	209	218	9	4.3
2.	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	265	320	55	20.7	270	331	60	22.5
3.	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	1283	1438	155	12.0	2077	2497	420	20.21
4.	Танхайрах	745	644	-101	-13.5	1134	958	-176	-15.5
5.	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	164	198	34	20.7	318	369	51	16.0
6.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	901	803	-98	-10.8	915	806	-109	-11.9
7.	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	58	49	-9	-15.5	70	74	4	5.7

Хянан шийдвэрлэсэн зарим хэргийг ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 11.9 хувиар, танхайрах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 15.5 хувиар тус тус буурсан бол хүнийг санаатай алах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 4.3 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 16 хувиар, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатайгаар учруулах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 22.5 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 20.2 хувиар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргээр ял шийтгүүлэгчдийн тоо 5.7 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Оногдуулсан ялын төрөл: Шүүхээр 2014 онд торгох ялаар 285, албадан ажил хийлгэх ялаар 442, баривчлах ялаар 1053, хорих ялаар 6277 хүн шийтгүүлсэн байна. Хорих ял шийтгүүлэгчдээс биечлэн эдлүүлсэн 2441, тэнссэн 3396, өршөөлд хамрагдсан 6 хүн байгаа бол насанд хүрээгүй 299 хүн, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 135 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна. Монгол Улс НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор цаазаар авах ял шийтгүүлсэн хүн байхгүй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал шүүхээс баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 1.8 хувиар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 2.1 хувиар тус тус өссөн бол албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний тоо 5.2 хувиар, торгох ял шийтгүүлсэн хүний тоо 3.4 хувиар тус тус буурчээ. /Хүснэгт 2.4/

Хүснэгт 2.4

Оногдуулсан ялын төрөл

№	Ялын төрөл	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Торгох	295	285	-10	-3.4
2.	Албадан ажил хийлгэх	466	442	-24	-5.2
3.	Баривчлах	1034	1053	19	1.8
4.	Хорих	6148	6277	129	2.1

Шүүхээс 2014 онд 285 хүнийг нийт 1 тэрбум 477 сая 241 мянга 600 төгрөгийн торгох ял, 502 хүнийг нийт 350 сая 563 мянга 666 төгрөгийн эд хөрөнгө хураах ялаар шийтгэж, тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах ялыг 244 хүнд, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 584 хүнд оногдуулжээ. /Хүснэгт 2.5/

Хүснэгт 2.5

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах ял оногдуулсан хүн


№	Ялын төрөл	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Эд хөрөнгө хураах	405	502	97	24
2.	Тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах	92	244	152	165
3.	Тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах	586	584	-2	-0.3

Хорих ялын хугацаа: Улсын хэмжээнд 2014 онд шүүхээс нийт 6277 хүнийг хорих ял шийтгэснээс 584 хүнд 1 жил, 2870 хүнд 1-3 жил, 1716 хүнийг 3-5 жил, 677 хүнд 5-8 жил, 47 хүнийг 8-10 жил, 247 хүнийг 10-15 жил, 94 хүнийг 15-20 жил, 42 хүнийг 20-25 жилийн хорих ялаар тус тус шийтгэсэн байна. /График 2.1/


Өнгөрсөн онтой харьцуулбал 20-25 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо өмнөх оноос 20 хувиар, 15-20 жил хорих ялаар шийтгүүлсэн хүний тоо 1.1 хувиар тус тус өсчээ.

График 2.1

Хорих ялын хугацаа




Хорих ялын дэглэм: Анхан шатны шүүхээс хорих ял оногдуулсан хүмүүсээс 5479 хүн буюу 87.2 хувьд ялыг жирийн дэглэмтэй хорих ангид, 756 хүн буюу 12 хувьд чанга дэглэмтэй хорих ангид, 39 хүн буюу 0.6 хувьд ялыг онцгой дэглэмтэй хорих ангид, 3 хүнд буюу 0.04 хувьд ялыг гянданд эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. /График 2.2/



Хорих ялын дэглэмийн төрлийг өмнөх онтой харьцуулбал жирийн дэглэмд хорих ялыг эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 1.9 хувиар өссөн бол чанга дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 0.8 хувиар, онцгой дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 17 хувиар тус тус буурсан байна.


Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг: Нийт ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр авч үзвэл 14-15 настай ял шийтгүүлэгчид 134 буюу 1.6 хувийг, 16-17 настай ял шийтгүүлэгчид 353 буюу 4.3 хувийг, 18-29 настай ял шийтгүүлэгчид 3980 буюу 48.7 хувийг тус тус эзэлж байна. Ял шийтгүүлэгчдийн дотор 18-29 настай ял шийтгүүлэгчид 3980 байгаа нь голлох хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 39 хүнээр буюу 1 хувиар, 35-аас дээш настай ял шийтгүүлэгчид 184 хүнээр буюу 8.8 хувиар тус тус өсчээ. Харин 14-15 настай ял шийтгүүлэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 72 хүнээр буюу 35 хувиар, 30-34 настай ял шийтгүүлэгчдийн тоо 32 хүнээр буюу 2.2 хувиар тус тус буурсан дүнтэй гарчээ. /График 2.3/



Ял шийтгүүлэгчдийн боловсролын түвшин: Нийт ял шийтгүүлсэн хүмүүсийн 1102 хүн буюу 13.4 хувь нь дээд, 2 хүн буюу 0.02 хувь нь техникийн болон мэргэжлийн анхан шатны, 300 хүн буюу 3.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3507 хүн буюу 42.8 хувь нь бүрэн дунд, 1655 хүн буюу 20.2 хувь нь суурь, 997 хүн буюу 12.1 хувь нь бага боловсролтой, байгаа бол 615 буюу 7.5 хувь нь боловсролгүй хүмүүс байна. Ял шийтгүүлэгчдийг боловсролын түвшинээр нь өмнөх онтой харьцуулсаныг авч үзвэл дээд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 15 хувиар, суурь боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 49.8 хувиар, боловсролгүй ял шийтгүүлэгчдийн тоо 4.8 хувиар тус тус өссөн бол бага боловсролтой ял шийтгүүлэгчид 1.7 хувиар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчид 13.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /График 2.4/

График 2.4

Ял шийтгүүлэгчдийн боловсрол



Ял шийтгүүлэгчдийн эрхэлж байсан ажил, сургууль: Нийт ял шийтгүүлсэн иргэдийн 61.1 хувь нь эрхэлсэн ажил сургуульгүй, 5.0 хувь нь оюутан, 3.8 хувь нь малчин, 2.8 хувь нь сурагч, 1.8 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 1.2 хувь нь төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн албан тушаалтан, 0.7 хувь нь төрийн тусгай албан хаагч, 0.4 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 0.28 хувь нь ялтан, 0.19 хувь нь улс төрийн албан тушаалтан, 0.13 хувь нь цэрэг байна. Нийт ял шийтгүүлэгчдээс эрхэлсэн ажил, сургуульгүй 5000 хүн байгаа бөгөөд нийт ял шийтгүүлэгчдийн 61.1 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 1.3 хувиар өссөн дүн юм. Түүнчлэн ял шийтгүүлсэн оюутан, сурагчдын тоо өмнөх оноос буурсан дүнтэй гарчээ. /График 2.5/

График 2.5

Ял шийтгүүлэгчдийн нийгмийн байдал



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд учирсан хохирлыг авч үзвэл амь хохирсон хүний тоо өмнөх оноос 71 хүнээр буюу 12.7 хувиар өссөн дүнтэй байна.

Гэмтлийн хувьд гэмт хэргийн улмаас хүнд гэмтсэн 720, хүндэвтэр гэмтэл авсан 853, хөнгөн гэмтсэн 1443 хүн байна. Гэмтлийн зэргийг өмнөх онтой харьцуулбал хүнд гэмтэл авсан хүний тоо 11.9 хувиар, хүндэвтэр гэмтэл авсан хүний тоо 30.5 хувиар, хөнгөн гэмтэл авсан хүний тоо 3.2 хувиар тус тус өсчээ. /Хүснэгт 2.6/

Хүснэгт 2.6

Гэмт хэргийн улмаас амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол

Үзүүлэлт		Он		Өсөлт, бууралт	
		2013	2014	Тоо	Хувь
Амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол	Амь хохирсон	555	626	71	12.7
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь хохирсон эмэгтэй	8	8	0	0
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь хохирсон насанд хүрээгүй этгээд	1	2	1	2 дахин
Гэмтэл	Хүнд	643	720	72	11.2
	Хүндэвтэр	653	853	200	30.6
	Хөнгөн	1397	1443	45	3.2

Улсын хэмжээнд 2014 онд шүүхээр шийдвэрлэсэн хохирлын нийт хэмжээ 78 тэрбум 169 сая 357 мянга 508 төгрөг байна. Үүнээс улсад учирсан хохирол 29 тэрбум 752 сая 216 мянга 6 төгрөг, аж ахуйн нэгжид учирсан хохирол 27 тэрбум 14 сая 223 мянга 968 төгрөг, иргэдэд учирсан хохирол 21 тэрбум 402 сая 917 мянга 534 төгрөг байна.

Хэргийн үлдэгдэл: Анхан шатны шүүхүүд тайлант хугацааны эцэст нийт 493 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 69 хэргээр буюу 12.3 хувиар буурсан эерэг үзүүлэлт юм. Үлдэгдэл хэргийг анхан шатны шүүх тус бүрээр авч үзвэл Сум дундын 26 дугаар шүүх 1 хэрэг, Сум дундын 29 дүгээр шүүх 3 хэрэг, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх 4 хэрэг, Сум дундын 16 дугаар шүүх 4 хэргийн үлдэгдэлтэй байгаа бол Дүүргийн Эрүүгийн

хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх 100 хэрэг, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх 72 хэрэг, Сум дундын 14 дүгээр шүүх 34 хэргийн үлдэгдэлтэй байна. Анхан шатны шүүхийн хэргийн үлдэгдэл өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа нь шүүхийн шүүн таслах ажиллагаа тасралтгүй, шуурхай явагдаж байгааг харуулж байна. /Хүснэгт 2.7/

Хүснэгт 2.7

Анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн үлдэгдэл

Шүүх		Хэргийн үлдэгдэл	Шүүх		Хэргийн үлдэгдэл
1	Сум дундын 1 дүгээр шүүх	23	18	Сум дундын 18 дугааршүүх	8
2	Сум дундын 2 дугаар шүүх	8	19	Сум дундын 19 дүгээршүүх	7
3	Сум дундын 3 дугаар шүүх	12	20	Сум дундын 20 дугааршүүх	8
4	Сум дундын 4 дүгээр шүүх	10	21	Сум дундын 21 дүгээршүүх	20
5	Сум дундын 5 дугаар шүүх	15	22	Сум дундын 22 дугааршүүх	6
6	Сум дундын 6 дугаар шүүх	7	23	Сум дундын 23 дугааршүүх	20
7	Сум дундын 7 дугаар шүүх	20	24	Сум дундын 24 дүгээршүүх	5
8	Сум дундын 8 дугаар шүүх	7	25	Сум дундын 25 дугааршүүх	5
9	Сум дундын 9 дүгээр шүүх	5	26	Сум дундын 26 дугааршүүх	1
10	Сум дундын 10 дугаар шүүх	14	27	Сум дундын 27 дугааршүүх	11
11	Сум дундын 11 дүгээр шүүх	11	28	Сум дундын 28 дугааршүүх	11
12	Сум дундын 12 дугаар шүүх	10	29	Сум дундын 29 дүгээршүүх	3
13	Сум дундын 13 дугаар шүүх	5	30	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	100
14	Сум дундын 14 дүгээр шүүх	34	31	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	72
15	Сум дундын 15 дугаар шүүх	6	32	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	4
16	Сум дундын 16 дугаар шүүх	4	33	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	13
17	Сум дундын 17 дугаар шүүх	8	-	НИЙТ	493

2013 онд хугацаа хэтэрсэн үлдэгдэл 4 байсан бол 2014 онд хугацаа хэтэрсэн үлдэгдэлгүй байна. /Хүснэгт 2.8/

Хүснэгт 2.8

Хэргийн үлдэгдэл

	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь
Тайлангийн эцсийн үлдэгдэл	562	493	-69	-12.2
Хугацаа хэтэрсэн үлдэгдэл	4	0	-4	-100

2.2. Давж заалдах шатны шүүх

Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд тайлант хугацаанд нийт 2251 хэрэг хүлээн авч, 2161 хэргийг хянан шийдвэрлэж тайлант хугацааны эцэст 50 хэргийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 40 хэрэгт эрх бүхий этгээд давж заалдах гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан байна. Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо өмнөх оноос 201 хэргээр буюу 10.3 хувиар өссөн бол үлдэгдэл хэргийн тоо 47.9 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.9		Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг			
Д/д	Утга	Он		Өсөлт, бууралт	
		2013он	2014он	Тоо	Хувь
1.	Хянан шийдвэрлэсэн бүх хэрэг	1960	2161	201	10.3
2.	Тогтоолыг хэвээр үлдээсэн	1012	1007	-5	-0.5
3.	Тогтоолд өөрчлөлт оруулсан бүгд	391	477	86	22
4.	Тогтоолыг хүчингүй болгосон бүгд	557	677	120	21.5
5.	Давж заалдсан гомдол эсэргүүцлээсээ татгалзсан	60	40	-20	-33.3
6.	Үлдэгдэл хэрэг	96	50	-46	-47.9
Тогтоолд өөрчлөлт оруулсан					
7.	Ял гэмт хэргийн хүнд хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй	174	155	-19	-10.9
Тогтоолд өөрчлөлт оруулсан үндэслэл					
8.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	217	280	63	29
9.	Шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй	50	52	2	4
10.	Хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн	26	6	-20	-76.9
11.	Хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн	19	78	59	4 дахин
12.	Бусад	122	187	65	53.3
Тогтоолыг хүчингүй болгосон					
13.	Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан	227	271	44	19.4
14.	Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан	302	383	81	26.8
15.	Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгосон	28	23	-5	-17.9
Тогтоолыг хүчингүй болгосон үндэслэл					
16.	Тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй	298	350	52	17.4
17.	ЭБШ хуулийг ноцтойгоор зөрчсөн	245	307	62	25.3

Шийдвэрийн чанар, тогтвортой байдал: Давж заалдах шатны шүүх нийт 2161 хэрэг хянан шийдвэрлэснээс 1007 хэрэгт буюу 46.5 хувьд анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, 477 хэрэгт буюу 22 хувьд нь тогтоолд өөрчлөлт оруулсан бол 677 хэрэгт буюу 31.3 хувьд нь тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. /Хүснэгт 2.9/

Өөрчлөлт оруулсан: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн магадлалын нийт магадлалд эзлэх хувь өмнөх оноос 5.1 хувиар буурсан бол тогтоолд өөрчлөлт

оруулж шийдвэрлэсэн магадлал 2.1 хувиар, тогтоолыг хүчингүй болгосон магадлалын эзлэх хувь 2.9 хувиар тус тус өссөн дүнтэй гарсан байна.

Анхан шатны шүүхийн тогтоолд “ял шийтгэл хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй” гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулсан тоо өмнөх оноос 10.9 хувиар буурсан бол Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулсан тоо 63 хэрэг буюу 29 хувиар өсчээ. Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн үндэслэл дотроос “шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй” үндэслэл 4 хувиар, “хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн” үндэслэл 4 дахин, “бусад” үндэслэл 53.3 хувиар тус тус өссөн бол “хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн” үндэслэл 76.9 хувиар буурчээ. /График 2.6/

График 2.6

Анхан шатны шүүхийн тогтоолд өөрчлөлт оруулсан үндэслэл



Хүчингүй болгосон: Анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн нийт 677 магадлалаас 271 буюу 40 хувьд нь шүүхийн тогтоолыг хүчингүй болгож хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хэргийг буцааж, 383 буюу 56.6 хувьд нь тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол 23 буюу 3.4 хувьд нь тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. /График 2.7/

График 2.7

Шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байдал



Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын үндэслэлээс “ЭБШ хуулийг ноцтой зөрчсөн” гэсэн үндэслэл өмнөх оноос 62 хэргээр буюу 25.3 хувиар өссөн байх тул шүүгч шийдвэр гаргахдаа процессын журмыг сайтар баримтлах, шүүхийн сургалтын агуулга, хөтөлбөрт процессын эрх зүйн сэдэв, чиглэлийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна. /Хүснэгт 2.10/

Хүснэгт 2.10

Анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон үндэслэл

Д/д	Утга	Он		Өсөлт, бууралт	
		2013	2014	Тоо	Хувь
ЭБШ хуулийг ноцтой зөрчсөн					
1	Шүүх хууль бус бүрэлдэхүүнээр тогтоол гаргасан	14	26	12	85.7
2	Хуульд зааснаар шүүгдэгчийг заавал байлцуулбал зохих байтал түүнийг байлцуулаагүй	0	0	0	-
3	Сэжигтэн, яллагдагч шүүгдэгчийг өмгөөлүүлэх эрхээр хангаагүй	5	4	-1	-20
4	Зөвлөлдөх тасалгаанд болсон шүүгчдийн зөвөлгөөний нууцыг задруулсан	0	0	0	-
5	Тогтоолд шүүгчийн хэн нэг нь гарын үсэг зураагүй	0	1	1	-
6	Хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл байгаагүй	0	1	1	-
7	Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч заавал оролцуулах хуулийн заалт зөрчсөн	0	1	1	-
8	Бусад	224	274	50	22.3

2.3. Хяналтын шатны шүүх

Улсын дээд шүүх 2014 онд нийт 648 хэрэг хүлээн авч, 484 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 52 хэрэгт Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж, албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд 93 хэргийг хянаад буцааж, тайлант хугацааны эцэст 19 хэргийн үлдэгдэлтэй байна. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 484 хэргээс 426 хэргийг гомдлын дагуу, 18 хэрэгт прокурорын эсэргүүцлээр, 40 хэргийг прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэжээ. Тайлангийн эцсийн үлдэгдэл 19 хэргээр нэмэгдсэн байна. /Хүснэгт 2.11/

Хүснэгт 2.11

Хяналтын шатны шүүн таслах ажиллагааны дүн

№	Утга	2013 он	2014 он	Өсөлт, бууралт /хувиар/
1.	Хүлээн авсан бүгд	691	648	-6.2
2.	Хуралдаанаар хянаж шийдвэрлэсэн бүгд	535	484	-9.5
3.	Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн	268	276	3
4.	Тогтоол магадлалд өөрчлөлт оруулсан бүгд	84	108	28.6
5.	Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бүгд	183	100	-45.4

Өөрчлөлт оруулсан үндэслэл

1.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	54	42	-22.2
2.	Шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй	17	7	-58.8
3.	Хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн	2	7	3.5
4.	Эрүүгийн хуулийн 55'1, 62'1 дугаар зүйл	4	7	75
5.	Хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн	2	5	2.5 дахин
6.	Бусад	5	40	8 дахин

Хүчингүй болгосон бүгд

1.	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан	75	55	-26.7
2.	Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаасан	5	14	2.8 дахин
3.	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	82	18	-78

Хянан шийдвэрлэсэн байдал

1.	Шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, магадлалыг хэвээр үлдээсэн	0	0	0
2.	Шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон	20	13	-35
3.	Шийтгэх тогтоол магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон	1	0	-100
4.	ЭБШ хуулийг ноцтойгоор зөрчсөн	86	24	-72.1
5.	Тайлангийн үеийн эцсийн үлдэгдэл	6	19	3.1 дахин

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт 484 хэргээс 276 хэрэгт буюу 57 хувьд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 108 хэрэгт буюу 22.3 хувьд өөрчилж, 100 хэрэгт буюу 20.6 хувьд нь тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.


Шүүхийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан үндэслэлийг авч үзвэл 42 хэрэгт буюу 38.8 хувьд нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, 7 хэрэгт буюу 6.4 хувьд нь шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй, 7 хэрэгт буюу 6.4 хувьд нь шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, 5 хэрэгт буюу 4.6 хувьд хуулийг жинхэнэ агуулгаас нь зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэж үзжээ.

Хяналтын шатны шүүх 100 тогтоол, магадлалыг хүчингүй болгосноос 55 хэрэг буюу 55 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан, 14 хэрэг буюу 14 хувийг шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцааж, 18 хэрэг буюу 18 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс 2014 онд шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн үндэслэлээс анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэсэн үндэслэл 24 хэрэгт буюу 24 хувийг, тогтоол, магадлалд дурдсан дүгнэлт нь жинхэнэ байдалтай нийцээгүй гэсэн үндэслэл 76 хэрэгт буюу 76 хувийг тус тус эзэлж байна. /График 2.8/

График 2.8

Тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн үндэслэл



ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРЭГ

3.1. Анхан шатны шүүх

Анхан шатны шүүх 2014 онд нийт 48431 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 8755 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, 33996 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, тайлант хугацааны эцэст нийт 5680 хэргийн үлдэгдэлтэй байна.

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 2013 онд өмнөх оноос 27 хувиар өссөн үзүүлэлттэй байсан бол 2014 онд өмнөх оноос 3.7 хувиар буурсан байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо өмнөх оноос буурсан нь УИХ-аар 2012 онд батлагдсан “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-ийн дагуу иргэд, хуулийн этгээд маргаанаа эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлсэнтэй холбоотой юм. Иргэд, хуулийн этгээд 2014 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид 6143 өргөдөл гаргаснаас 5122 маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар шийдвэрлэсэн байх бөгөөд үүний 2847 маргаан буюу 55.6 хувьд нь эвлэрэл амжилттай болсон байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг шүүх тус бүрээр авч үзвэл Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх 8005 хэрэг, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүх 7869 хэрэг шийдвэрлэсэн нь 2014 онд улсын хэмжээнд нийт хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн 46.7 хувийг эзэлж байгаа бол Сум дундын 7 дугаар шүүх 1380 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 4.05 хувь, Сум дундын 16 дугаар шүүх 119 хэрэг буюу 0.35 хувийг эзэлж байна. /Хүснэгт 3.1/

Хүснэгт 3.1

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг

№	Шүүх	Шийдвэрлэсэн хэрэг	№	Шүүх	Шийдвэрлэсэн хэрэг
1	Сум дундын 1 дүгээр шүүх	765	18	Сум дундын 18 дугаар шүүх	389
2	Сум дундын 2 дугаар шүүх	735	19	Сум дундын 19 дүгээр шүүх	503
3	Сум дундын 3 дугаар шүүх	675	20	Сум дундын 20 дугаар шүүх	669
4	Сум дундын 4 дүгээр шүүх	633	21	Сум дундын 21 дүгээр шүүх	364
5	Сум дундын 5 дугаар шүүх	430	22	Сум дундын 22 дугаар шүүх	200
6	Сум дундын 6 дугаар шүүх	215	23	Сум дундын 23 дугаар шүүх	533
7	Сум дундын 7 дугаар шүүх	1380	24	Сум дундын 24 дүгээр шүүх	815
8	Сум дундын 8 дугаар шүүх	488	25	Сум дундын 25 дугаар шүүх	633
9	Сум дундын 9 дүгээр шүүх	257	26	Сум дундын 26 дугаар шүүх	290
10	Сум дундын 10 дугаар шүүх	1004	27	Сум дундын 27 дугаар шүүх	1179
11	Сум дундын 11 дүгээр шүүх	365	28	Сум дундын 28 дугаар шүүх	563
12	Сум дундын 12 дугаар шүүх	569	29	Сум дундын 29 дүгээр шүүх	253
13	Сум дундын 13 дугаар шүүх	318	30	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	8005
14	Сум дундын 14 дүгээр шүүх	1152	31	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	7869

15	Сум дундын 15 дугаар шүүх	491	32	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	600
16	Сум дундын 16 дугаар шүүх	119	33	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	861
17	Сум дундын 17 дугаар шүүх	674	-	Нийт	33996

Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал: Анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт 33996 хэргээс 20910 буюу 61.5 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 11271 хэрэг буюу 33.2 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 1815 хэрэг буюу 5.3 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгожээ. /График 3.1/

График 3.1

Иргэний хэрэг, маргааны хянан шийдвэрлэсэн байдал



Өмнөх онтой харьцуулбал ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 12 хэргээр буюу 0.1 хувиар, ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 1034 хэргээр буюу 2.3 дахин өссөн бол ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэсэн хэргийн тоо 2364 хэргээр буюу 12.8 хувиар буурчээ.

Шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн нийт 20910 хэргээс 17245 хэрэг буюу 82.5 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, 2659 хэрэг буюу 12.7 хувьд нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол 1006 хэрэг буюу 4.8 хувьд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл: Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 14708 буюу 43.3 хувийг, ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 12421 буюу 36.5 хувийг, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4207 буюу 12.4 хувийг, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 1377 буюу 4.05 хувийг тус тус эзэлжээ. /График 3.2/

График 3.2

Шийдвэрлэсэн хэрэг (Маргааны төрлөөр)



Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэсэн хэрэг 10807 байгаа бөгөөд өмнөх оноос 2193 хэргээр буюу 16.9 хувиар буурсан бөгөөд нийт иргэний хэргийн 31.8 хувийг эзэлж байгаа нь 2013 онтой харьцуулахад 5.01 хувиар буурсан үзүүлэлт юм.

Хянан шийдвэрлэсэн хэрэг маргаанаас Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 27.5 хувиар, Газрын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 41.9 хувиар, Нийгмийн даатгалын багц хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 2.2 дахин өсчээ. Харин ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 20.2 хувиар, Компанийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 55.6 хувиар, Татварын ерөнхий хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 26 хувиар тус тус буурсан байна. “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэрэг, маргааны тоо нэмэгдсэн байна. /Хүснэгт 3.2/

Хүснэгт 3.2

Д/д	Хэрэг, маргааны төрөл	Бүтэн жил		Өсөлт, бууралт		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү + ,-
		2013	2014	Тоо	Хувь	2013	2014	
1	Нийт шийдвэрлэсэн иргэний хэрэг	35314	33996	-1318	-3.73	100.0	100.0	
2	Иргэний эрх зүйн маргаан	12738	14708	1970	15.47	36.07	43.26	7.19
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	15571	12421	-3150	-20.2	44.09	36.54	-7.56
4	Гэр бүлийн эрх зүйн маргаан	4276	4207	-69	-1.61	12.11	12.37	0.27
5	Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	1080	1377	297	27.5	3.058	4.05	0.99
6	Бусад: Үүнээс							
7	Газрын тухай хуулиар	93	132	39	41.94	0.263	0.388	0.12
8	Дампуурлын тухай хуулиар	11	13	2	18.18	0.031	0.038	0.01
9	Компаний тухай хуулиар	18	8	-10	-55.6	0.051	0.024	-0.03
10	Нийгмийн даатгалын багц хуулиар	148	326	178	2.2 дахин	0.419	0.959	0.54
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	162	118	-44	-27.2	0.459	0.347	-0.11
12	Татварын ерөнхий хуулиар	412	305	-107	-26	1.167	0.897	-0.27

13	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	6	4	-2	-33.3	0.017	0.012	-0.01
14	Төрийн албаны тухай хуулиар	2	3	1	50	0.006	0.009	0
15	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулиар	52	55	3	5.769	0.147	0.162	0.01
16	Бусад хуулиар	745	319	-426	-57.2	2.11	0.938	-1.17

Иргэний эрх зүйн маргааны дотор худалдах-худалдан авах болон арилжааны гэрээтэй холбогдсон маргаан 4328 хэрэг буюу 29.4 хувь, зээлийн гэрээтэй холбогдсон маргаан 2911 хэрэг буюу 19.8 хувь, ажил гүйцэтгэх гэрээтэй холбогдсон маргаан 1035 хэрэг буюу 7.03 хувийг эзэлж байгаа бол франчайз, аялал жуулчлалын гэрээ, хөрөнгө итгэмжлэх гэрээтэй холбогдсон маргаан байхгүй байна.

Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн хэргээс ажилласан жил тогтоохтой холбоотой 7891 хэрэг байгаа нь ИХШХШТХ-иар шийдвэрлэгдсэн нийт хэргийн 63.5 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх жилээс 2678 хэргээр буюу 25.3 хувиар буурсан байна.

Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэрэгт гэрлэлт цуцалсан 3182 хэрэг байгаа нь нийт гэр бүлийн эрх зүйн маргааны 75.6 хувийг эзэлж байгаа бол эцэг, эх байх эрх хасах 21 хэрэг шийдвэрлэгдсэн нь 0.5 хувийг эзэлж байна.

Хөдөлмөрийн эрх зүйн маргааны хувьд ажлаас үндэслэлгүй халагдсан тухай маргаантай хэрэг нийт Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн 742 буюу 53.9 хувь, цалин хөлсний маргаантай хэрэг 475 буюу 34.5 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 3.3/

Хүснэгт 3.3

Хэрэг, маргааны төрөл

Д/д	Шүүх	Иргэний эрх зүйн маргаан	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	Бусад эрх зүйн маргаан	НИЙТ
1.	Сум дундын 1 дүгээр шүүх	154	511	43	36	21	765
2.	Сум дундын 2 дугаар шүүх	211	361	47	79	37	735
3.	Сум дундын 3 дугаар шүүх	137	398	75	25	40	675
4.	Сум дундын 4 дүгээр шүүх	139	402	50	16	26	633
5.	Сум дундын 5 дугаар шүүх	138	212	34	36	10	430
6.	Сум дундын 6 дугаар шүүх	78	105	24	5	3	215
7.	Сум дундын 7 дугаар шүүх	511	535	216	59	59	1380
8.	Сум дундын 8 дугаар шүүх	127	98	48	198	17	488
9.	Сум дундын 9 дүгээр шүүх	130	67	31	3	26	257
10.	Сум дундын 10 дугаар шүүх	547	322	105	20	10	1004
11.	Сум дундын 11 дүгээр шүүх	55	250	42	9	9	365
12.	Сум дундын 12 дугаар шүүх	153	332	45	29	10	569
13.	Сум дундын 13 дугаар шүүх	53	222	30	12	1	318
14.	Сум дундын 14 дүгээр шүүх	525	383	161	63	20	1152
15.	Сум дундын 15 дугаар шүүх	202	166	87	6	30	491

16.	Сум дундын 16 дугаар шүүх	54	40	19	3	3	119
17.	Сум дундын 17 дугаар шүүх	123	458	75	10	8	674
18.	Сум дундын 18 дугаар шүүх	65	295	23	4	2	389
19.	Сум дундын 19 дүгээр шүүх	189	251	45	10	8	503
20.	Сум дундын 20 дугаар шүүх	251	195	82	9	132	669
21.	Сум дундын 21 дүгээр шүүх	126	175	56	4	3	364
22.	Сум дундын 22 дугаар шүүх	106	53	25	4	12	200
23.	Сум дундын 23 дугаар шүүх	193	272	40	16	12	533
24.	Сум дундын 24 дүгээр шүүх	188	515	41	45	26	815
25.	Сум дундын 25 дугаар шүүх	140	394	51	26	22	633
26.	Сум дундын 26 дугаар шүүх	35	237	11	4	3	290
27.	Сум дундын 27 дугаар шүүх	381	646	109	32	11	1179
28.	Сум дундын 28 дугаар шүүх	150	343	54	10	6	563
29.	Сум дундын 29 дүгээр шүүх	144	69	24	12	4	253
30.	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	4220	1987	1164	306	328	8005
31.	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	4587	1470	1208	251	353	7869
32.	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	348	142	69	21	20	600
33.	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	248	515	73	14	11	861
НИЙТ ДҮН		14708	12421	4207	1377	1283	33996

Хэргийн үлдэгдэл: Анхан шатны шүүх тайлант хугацааны эцэст нийт 5680 иргэний хэргийн үлдэгдэлтэй байна. Үүнээс хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж байгаа хэрэг 3683 буюу 64.8 хувь, хойшлуулсан хэрэг 893 буюу 15.7 хувь, түдгэлзүүлсэн хэрэг 590 буюу 10.4 хувь, хуулийн хугацаа хэтэрсэн хэрэг 514 буюу 9.1 хувийг тус тус эзэлж байна.

Тайлангийн эцсийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулбал 1052 хэргээр буюу 22.7 хувиар өсчээ. Энэ нь хойшлуулсан хэрэг 435 буюу 94.9 хувиар, түдгэлзүүлсэн хэрэг 6 буюу 1.02 хувиар, хуулийн хугацаа хэтэрсэн хэрэг 300 буюу 2.4 дахин өссөнтэй холбоотой юм. /Хүснэгт 3.4/

Хүснэгт 3.4		Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдэл			
		2013 он	2014 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
Д/д	Тайлангийн эцсийн үлдэгдэл	4628	5680	1052	22.7
1.	Хуулийн хугацаанд	3372	3683	311	9.2
2.	Хойшлуулсан	458	893	435	94.9
3.	Түдгэлзүүлсэн	584	590	6	1.02
4.	Хуулийн хугацаа хэтэрсэн	214	514	300	2.4 дахин

Анхан шатны шүүх дэх иргэний хэргийн үлдэгдлээс түдгэлзүүлсэн, хуулийн хугацаа хэтэрсэн хэргийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь цаашид хуулийн хугацаа хэтэрч байгаа шалтгаан, нөхцлийг тодруулах, түүнд тохирсон хэргийн хөдөлгөөний үр нөлөөтэй удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 3.5

Хэргийн үлдэгдлийн шалтгаан (Шүүхээр)

Д/д	Шүүх	Тайлангийн эцсийн үлдэгдэл	Үүнээс:			
			Хуулийн хугацаанд	Хойш- луулсан	Түдгэл- зүүлсэн	Хуулийн хугацаа хэтэрсэн
1.	Сум дундын 1 дүгээр шүүх	75	71	0	4	0
2.	Сум дундын 2 дугаар шүүх	93	81	0	12	0
3.	Сум дундын 3 дугаар шүүх	69	59	9	1	0
4.	Сум дундын 4 дүгээр шүүх	86	74	2	10	0
5.	Сум дундын 5 дугаар шүүх	63	52	0	11	0
6.	Сум дундын 6 дугаар шүүх	18	13	0	5	0
7.	Сум дундын 7 дугаар шүүх	126	102	3	20	1
8.	Сум дундын 8 дугаар шүүх	34	29	0	5	0
9.	Сум дундын 9 дүгээр шүүх	24	20	0	4	0
10.	Сум дундын 10 дугаар шүүх	80	65	1	14	0
11.	Сум дундын 11 дүгээр шүүх	48	40	0	8	0
12.	Сум дундын 12 дугаар шүүх	60	48	0	12	0
13.	Сум дундын 13 дугаар шүүх	35	28	0	7	0
14.	Сум дундын 14 дүгээр шүүх	175	155	3	17	0
15.	Сум дундын 15 дугаар шүүх	60	55	0	4	1
16.	Сум дундын 16 дугаар шүүх	9	5	1	3	0
17.	Сум дундын 17 дугаар шүүх	71	65	0	6	0
18.	Сум дундын 18 дугаар шүүх	27	23	1	3	0
19.	Сум дундын 19 дүгээр шүүх	48	43	0	5	0
20.	Сум дундын 20 дугаар шүүх	93	70	5	18	0
21.	Сум дундын 21 дүгээр шүүх	45	34	3	8	0
22.	Сум дундын 22 дугаар шүүх	27	23	0	4	0
23.	Сум дундын 23 дугаар шүүх	59	45	4	10	0
24.	Сум дундын 24 дүгээр шүүх	79	70	0	9	0
25.	Сум дундын 25 дугаар шүүх	62	59	1	2	0
26.	Сум дундын 26 дугаар шүүх	22	21	0	1	0
27.	Сум дундын 27 дугаар шүүх	163	145	5	13	0
28.	Сум дундын 28 дугаар шүүх	63	55	0	7	1
29.	Сум дундын 29 дүгээр шүүх	29	24	0	5	0
30.	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	2126	1215	457	180	274
31.	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	1601	802	398	169	232
32.	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	88	74	0	11	3
33.	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	22	18	0	2	2
НИЙТ ДҮН		5680	3683	893	590	514

3.2. Давж заалдах шатны шүүх

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд улсын хэмжээнд нийт 2116 хэрэг хүлээн авч, 1947 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс 742 хэрэг буюу 38.1 хувьд нь

анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 593 хэрэг буюу 30.5 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 612 хэрэг буюу 31.4 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, жилийн эцэст 95 хэргийн үлдэгдэлтэй байна. Нийт 46 хэрэгт давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 13 хэрэгт эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзаж буцаан авсан байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах нийт 10 хүсэлт гаргаснаас 1 хүсэлтийг хангаж, 9 хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн тоо өмнөх онтой харьцуулахад 125 хэргээр буюу 6.8 хувиар өсчээ. Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн шийдвэрлэсэн хэргийн тоо 3.7 хувиар буурсан ч Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оноос 6.8 хувиар өссөн бйагаа нь давж заалдах шатны шүүхийн тойргийн зохион байгуулалт оновчтой болсныг харуулж байна. /Хүснэгт 3.6/

Хүснэгт 3.6

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэсэн байдал

Д/д	Маргааны төрөл	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1.	Нийт /хүлээн авсан/	2011	2116	105	5.2
2.	Нийт шийдвэрлэсэн	1837	1962	125	6.8
3.	Хянан шийдвэрлэсэн бүгд	1806	1947	141	7.8
4.	Арбитрийн шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн	15	5	-10	-66.6
5.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	16	10	-6	-37.5
6.	Үлдэгдэл	103	95	-8	-7.7

Шийдвэрийн чанар, тогтвортой байдал: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлал 79 хэргээр буюу 9.6 хувиар буурсан бол өөрчлөлт оруулсан магадлал 101 хэргээр буюу 20.5 хувиар, хүчингүй болгосон магадлал 119 хэргээр буюу 24.1 хувиар тус тус өсчээ. Давж заалдах шатны шүүхээс шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт хэргээс 742 шийдвэрийг хэвээр үлдээж, 593 шийдвэрт өөрчлөлт оруулж, 612 шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хэвээр үлдээсэн тоо буурч, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь анхан шатны шүүхийн шийдвэрийн чанар хангалттай бус байгааг харуулж байна. /Хүснэгт 3.7/

Хүснэгт 3.7


Давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал

Д/д	Хянан шийдвэрлэсэн байдал	2013 он	2014 он	Өсөлт бууралт	
				Тоо	Хувь
1	Хэвээр үлдээсэн	821	742	-79	-9.6
2	Өөрчлөлт оруулсан	492	593	101	20.5
3	Хүчингүй болгосон	493	612	119	24.1
НИЙТ ДҮН		1806	1947	141	7.8

Өөрчлөлт оруулсан: 2014 онд иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдлыг авч үзвэл, шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн магадлал 573 хэрэг буюу 96.6 хувь, шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон магадлал 20 хэрэг буюу 3.4 хувийг тус тус эзэлсэн байна. /График 3.3/

График 3.3

Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдал



Хүчингүй болгосон: Шүүхийн статистик мэдээнээс үзвэл “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” гэх үндэслэл 295 хэрэгт буюу 41.8 хувь, “шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлээр 114 хэрэгт буюу 18.6 хувийг тус тус эзэлжээ. /Хүснэгт 3.8/

Хүснэгт 3.8

Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл

Д/д	Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл	Бүтэн жил				Хүчингүй болсон хэрэгт эзлэх хувь	
		2013 он	2014 он	Тоо	Хувь	2013 он	2014 он
1.	Шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	75	114	39	52	15	18.6
2.	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	14	31	17	2.2 дахин	2.8	5.1
3.	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн	72	47	-25	-34.7	14.4	7.8
4.	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	9	11	2	22	1.8	1.8
5.	Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсвэл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	0	1	1	100	0	0.2
6.	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн	0	0	0	0	0	0
7.	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн	171	100	-71	-41.5	34.3	16.3
8.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	139	295	156	2.1 дахин	28.2	48.1
9.	ИХШХШТХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн	13	13	0	0	2.6	2.1
НИЙТ ДҮН		493	612	119	24.1	100.0	100.0

Анхан шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхдээ ИХШХШТХ-ийн журам зөрчих, хуулийг зөв тайлбарлаж хэрэглэх, зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангах шаардлагатай юм.

3.3. Хяналтын шатны шүүх

Улсын дээд шүүх өмнөх оны үлдэгдэл 30 хэрэг дээр хяналтын шатны журмаар 879 хэрэг, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 103 хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүсэлттэй 38 хэрэг, нийт 1050 хэрэг хүлээн авснаас 1017 хэргийг хянан шийдвэрлэжээ. Үүнээс хуралдаанд оруулаагүй шийдвэрлэсэн 139 хэрэг буюу 13.7 хувийг, хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн 841 хэрэг буюу 82.7 хувийг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн 37 хэрэг буюу 3.6 хувийг тус тус эзэлж байна.

Хяналтын шатны шүүх нийт 841 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон нь 503 хэрэг буюу 59.8 хувь, шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан нь 132 хэрэг буюу 15.7 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн нь 89 хэрэг буюу 10.6 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон нь 4 хэрэг буюу 0.5 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь 11 хэрэг буюу 1.3 хувь, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нь 102 хэрэг буюу 12.1 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 3.9/

Хүснэгт 3.9		Хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг (өмнөх онтой харьцуулсан)			
№	Үзүүлэлт	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1	Хүлээн авсан хэрэг	1013	1050	37	3.7
2	Хянаад хариу өгсөн хэрэг	182	139	-43	-23.6
3	Нийт шийдвэрлэсэн хэрэг	983	1017	34	3.5
4	Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаанаар хянан шийдвэрлэсэн	0	0	0	0
5	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	759	841	82	10.8
6	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	42	37	-5	-11.9
7	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон	465	503	38	8.2
8	Шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан	100	132	32	32
9	Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн	54	89	35	64.8
10	Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон	5	4	-1	-20
11	Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	8	11	3	37.5
12	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	127	102	-25	-19.7
13	Үлдэгдэл	30	33	3	10

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нийт хэрэгт “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж, хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 49 хэрэг буюу 48 хувийг, “Шүүх өөр хуулийг эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл 33 хэрэг буюу 32.4 хувийг тус тус эзэлсэн байна. /Хүснэгт 3.10/

Хүснэгт 3.10

Хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл

Д/д	Хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	тоо	хувь
1.	Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	64	33	-31	-48.4
2.	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	1	1	0	0
3.	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн	17	19	2	11.8
4.	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	4	0	-4	-100
5.	Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	0	0	0	0
6.	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь илэрсэн	0	0	0	0
7.	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн	41	49	8	19.5
Нийт		127	102	-25	-19.6

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хяналтын шатны шүүхээс “хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн” гэх үндэслэл 11.8 хувиар, “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн” гэх үндэслэл 19.5 хувиар тус тус өссөн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам баримтлах, шүүх нотлох баримтыг тогтоох, үнэлэхэд цаашид анхаарах шаардлагатайг харуулж байна.

ДӨРӨВ. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

4.1. Анхан шатны шүүх

Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд 2014 онд нийт 2437 хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас 648 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 1187 хэргийг хянан шийдвэрлэж, тайлангийн эцсийн байдлаар 602 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хянан шийдвэрлэсэн 1187 хэргийн 184 хэрэгт нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзаж, 64 хэрэгт хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрч, 90 хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч эвлэрч, 849 хэргийг ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлээр шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хүлээн авсан нийт хэрэг, нэхэмжлэл 12.3 хувь буюу 267 хэргээр, хянан шийдвэрлэсэн хэрэг 7.3 хувь буюу 81 хэргээр, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан буюу буцаасан хэрэг 21.6 хувь буюу 115 хэргээр, шийдвэрлэгдээгүй үлдсэн хэрэг 13.3 хувь буюу 71 хэргээр тус тус өссөн байна.

Хүснэгт 4.1 Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоо (өмнөх онтой харьцуулсан)

Д/д	Шүүх	Он		Өсөлт, Бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1.	Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	32	46	14	43.75
2.	Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	66	39	-27	-40.91
3.	Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	20	28	8	40.00
4.	Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	15	35	20	2.3 дахин
5.	Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүх	17	10	-7	-41.18
6.	Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүх	66	66	0	-
7.	Захиргааны хэргийн анхан шатны 7 дугаар шүүх	14	18	4	28.57
9.	Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүх	25	26	1	4.00
8.	Захиргааны хэргийн анхан шатны 9 дүгээр шүүх	10	12	2	20.00
10.	Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүх	26	22	-4	-15.38
11.	Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүх	55	46	-9	-16.36
12.	Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүх	19	8	-11	-57.89
13.	Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүх	27	38	11	40.74
14.	Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүх	9	13	4	44.44
15.	Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүх	29	24	-5	-17.24
16.	Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүх	21	36	15	71.43
17.	Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүх	28	33	5	17.86
18.	Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүх	41	29	-12	-29.27
19.	Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүх	13	24	11	84.62
20.	Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх	573	634	61	10.65
-	ДҮН	1106	1187	81	7.32

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн ачаалал өмнөх онтой харьцуулахад дунджаар 7.32 хувиар өсчээ. Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх (2.3


дахин), Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүх (84.62%), Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүх (71.43%), Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүх (44.44%), Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх (43.75%), Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүх (40.74%)-ийн хэргийн ачаалал харьцангуй өссөн бол Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүх (-57.89%), Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүх (-41.18%), Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүх (-40.91%), Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүх (-29.27%)-ийн хэргийн ачаалал буурсан байна. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шийдвэрлэсэн хэрэг улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн нийт захиргааны хэргийн 53.41 хувийг дангаар эзэлж байна.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, буцаасан: Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2014 онд нийт 2437 хэрэг хүлээн авснаас нэхэмжлэлийн 26.6 хувь буюу 648 хэргийг хүлээн авахаас татгалзаж, буцаах, шилжүүлэх зэрэг ажиллагааг хийжээ. Үүнээс 511 хэргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ЗХХШТХ гэх/ 34.1 дэх хэсэгт заасныг үндэслэн хэрэг үүсгэхээс өмнө татгалзсан бол 46 хэргийг ЗХХШТХ-ийн 66.2-т заасны дагуу шилжүүлж (хэрэг үүсгэснээс хойш татгалзсан тоо хамт тоологдож байгаа болно), 73 хэргийг ЗХХШТХ-ийн 33 дугаар зүйлд зааснаар буюу нэхэмжлэгчээс шүүгчийн тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаж ирүүлээгүй үндэслэлээр буцааж, 18 хэргийг ИХШШТХ-ийн 100 дугаар зүйлд заасны дагуу “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй” үндэслэлээр нэхэмжлэгчид буцаасан байна.

Хянан шийдвэрлэсэн нийт хэрэг: Тайлант хугацаанд Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн нийт 1187 хэргээс 72 хувь буюу 849 хэргийг ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн бол 28 хувь буюу 338 хэргийг хялбаршуулсан журмаар тус тус шийдвэрлэжээ. /График 4.1/

График 4.1

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг




Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг: Тайлант хугацаанд Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд нийт 338 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нь өнгөрсөн оноос 15 хэргээр буюу 4.6 хувиар өссөн дүнтэй байна. Хялбаршуулсан журмаар

шийдвэрлэсэн хэргээс 54.4 хувьд нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, 18.9 хувьд нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрсөн бол 26.6 хувьд нь нэхэмжлэгч, хариуцагч эвлэрсэн байна. /График 4.2/

График 4.2


Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг



Шийдвэрлэсэн хэрэг /ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлд зааснаар/: Нийт 849 хэрэг шийдвэрлэснээс 402 хэрэг буюу 47.3 хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, 309 хэрэг буюу 36.39 хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 88 хэрэг буюу 10.36 хувьд нь нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгож, 50 хэрэг буюу 5.88 хувьд нь дахин шинээр акт гартал захиргааны актыг түдгэлзүүлжтус тус шийдвэрлэсэн байна. /График 4.3/

График 4.3

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн төрөл



Шийдвэрлэсэн хэрэг маргааны төрөл: Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн 33 хувь буюу 386 хэргийг газрын маргаан, 25 хувь буюу 297 хэргийг төрийн албаны маргаан, 7 хувь буюу 81 хэргийг татварын маргаан, 7 хувь буюу 81 хэргийг төрийн хяналт, шалгалттай холбоотой маргаан, 5 хувь буюу 59 хэргийг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан, 4 хувь буюу 43 хэргийг ашигт малтмалтай холбоотой маргаан, 3.36 хувь буюу 40 хэргийг тендерийн маргаан, 3 хувь буюу 28 хэргийг иргэний

бүртгэлтэй холбоотой маргаан, 1.17 хувь буюу 14 хэргийг сонгуулийн маргаан тус тус эзэлж байгаа нь нийт хянан шийдвэрлэсэн хэргийн 88.53 хувийг эзэлж байна. /График 4.4/



Эдгээр маргааныг өнгөрсөн онд хянан шийдвэрлэсэн хэргийн тоотой харьцуулбал иргэний бүртгэлтэй холбоотой маргаан 2.2 дахин, төрийн хяналт, шалгалттай холбоотой бусад маргаан 76.09 хувиар, төрийн албаны маргаан 46.31 хувиар, газрын маргаан 37.86 хувиар, татварын маргаан 24.62 хувиар тус тус өссөн дүнтэй байгаа бол сонгуулийн маргаан 86.41 хувиар, ашигт малтмалтай холбоотой маргаан 40.28 хувиар, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан 32.95 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 4.2/

Хүснэгт 4.2 Захиргааны хэргийн маргааны төрөл (Өмнөх онтой харьцуулсан)

Д/д	Маргааны төрөл	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1	Газрын маргаан	280	386	106	37.86
2	Төрийн албаны маргаан	203	297	94	46.31
3	Сонгуулийн маргаан	103	14	-89	-86.41
4	Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	88	59	-29	-32.95
5	Ашигт малтмалтай холбоотой маргаан	72	43	-29	-40.28
6	Татварын маргаан	65	81	16	24.62
7	Төрийн хяналт шалгалттай холбоотой бусад маргаан	46	81	35	76.09
8	Иргэний бүртгэлтэй холбоотой маргаан	13	28	15	2.2 дахин
9	Бусад	227	198	-29	-12.78
10	Нийт	1097	1187	90	8.2

Захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийн төрөл: Захиргааны хэрэгт хариуцагчаар татагдсан төрийн захиргааны байгууллагуудыг өнгөрсөн жилийн байдалтай

харьцуулж үзвэл улсын ханялт, шалгалтын байгууллага хариуцагчаар татагдсан хэргийн тоо 68.67 хувиар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг хариуцагчаар татагдсан хэргийн тоо 45.63 хувиар, бүх шатны Засаг дарга хариуцагчаар татагдсан хэргийн тоо 37.70 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Энэ нь байгууллага, албан тушаалтан захиргааны акт гаргахдаа хуульд заасан үндэслэл, журмыг сайтар баримтлах, гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлийг иргэд, шийдвэр чиглэсэн этгээдэд хангалттай тайлбарлах шаардлагатайг харуулж байна. Бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн нийтийн хурал хариуцагчаар татагдсан хэргийн тоо 10.57 хувиар буурсан байна. /Хүснэгт 4.3/

Хүснэгт 4.3

Маргааны төрөл		Захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагч			
		Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
Нэхэмжлэгч	Иргэн	689	955	266	38.61
	Хуулийн этгээд	461	443	-18	-3.9
	Бүх шатны засаг дарга	366	504	138	37.7
Хариуцагч	МУЗГ-ын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг	223	204	-19	-8.52
	Бүх шатны ИТХ, ИНХ	123	110	-13	-10.57
	Аймаг, нийслэлийн засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг	103	150	47	45.63
	Улсын хяналт, шалгалтын байгууллага	83	140	57	68.67

Хэргийн үлдэгдэл: Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн үлдэгдэл хэргийг өнгөрсөн онтой харьцуулбал 13.37 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс хуулийн хугацаанд байгаа үлдэгдэл хэрэг 7.35 хувиар, хойшлуулсан хэргийн үлдэгдэл 4.76 хувиар, түдгэлзүүлсэн хэргийн үлдэгдэл 64.06 хувиар тус тус өссөн ба улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд хуулийн хугацаа хэтрүүлсэн үлдэгдэл хэрэг байхгүй байна. /Хүснэгт 4.4/

Хүснэгт 4.4

Д/д Тайлангийн эцсийн үлдэгдэл		Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013	2014	Тоо	Хувь
		2013	2014	Тоо	Хувь
1	Хуулийн хугацаанд	299	321	22	7.3
2	Хойшлуулсан	168	176	8	4.7
3	Түдгэлзүүлсэн	64	105	41	64.06
4	Нийт	531	602	71	13.37

Хүснэгт 4.5

Д/д	Шүүх	Тайлангийн эцсийн үлдэгдэл	Хэргийн үлдэгдлийн шалтгаан (Шүүхээр)		
			Хуулийн хугацаанд	Хойшлуулсан	Түдгэлзүүлсэн
1.	Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	10	7	1	2
2.	Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	8	7	-	1
3.	Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	9	6	1	2
4.	Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	11	8	-	3
5.	Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүх	1	1	-	-
6.	Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүх	7	6	-	1
7.	Захиргааны хэргийн анхан шатны 7 дугаар шүүх	4	1	3	-
9.	Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүх	2	2	-	-
8.	Захиргааны хэргийн анхан шатны 9 дүгээр шүүх	2	-	-	2
10.	Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүх	5	5	-	-
11.	Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүх	6	5	-	1
12.	Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүх	3	3	-	-
13.	Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүх	4	4	-	-
14.	Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүх	3	3	-	-
15.	Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүх	3	2	-	1
16.	Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүх	3	3	-	-
17.	Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүх	8	4	-	4
18.	Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүх	12	11	-	1
19.	Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүх	3	3	-	-
20.	Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх	498	240	171	87
НИЙТ ДҮН		602	321	176	105

Захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, шийдвэрлэсэн хэргийн тоо жил дараалан өсч байгаа нь иргэдийн эрх зүйн мэдлэг, соёл, ухамсар дээшилж, захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус, буруутай үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхэд хандаж сэргээлгэх эерэг хандлага төлөвшиж байгааг харуулж байна.

4.2. Давж заалдах шатны шүүх

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2014 онд нийт 933 хэрэг хүлээн авснаас 883 хэргийг хянан шийдвэрлэж, тайлант үеийн эцэст 50 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хянан шийдвэрлэсэн 883 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан 512 хэрэг, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан 343 хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан 3 хэрэг, бусад 25 хэрэг байна. /Хүснэгт 4.6/

Хүснэгт 4.6

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэсэн байдал

Д/д	Маргааны төрөл	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1.	Нийт /хүлээн авсан/	660	933	273	41.36
2.	Хянан шийдвэрлэсэн бүгд	598	883	285	47.66
3.	Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан бүгд	384	512	128	33.33
4.	Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан бүгд	185	343	158	85.41
5.	Бусад	26	25	-1	-3.85
6.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	3	3	0	-
7.	Үлдэгдэл	62	50	-12	-19.35

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь өмнөх оны үеэс 47.6 хувиар их хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Энэ нь төрийн байгууллага, албан тушаалтан болон тэдний захиргааны акт, үйлдлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн иргэдийн аль алиных нь маргаанд ялах хүсэл эрмэлзэлтэй, төр ба иргэдийн ашиг сонирхолтой холбоотой байна.

Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн нийт 512 хэргээс 283 буюу 55 хувьд шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 103 буюу 20 хувьд нь шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 126 буюу 25 хувьд нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож тус тус шийдвэрлэжээ. /Хүснэгт 4.7/

Хүснэгт 4.7

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан шийдвэрлэсэн байдал


Д/д	Шүүхийн нэр	Бүтэн жил		Өсөлт бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1	Хэвээр үлдээсэн	197	283	86	43.6
2	Өөрчлөлт оруулсан	75	103	28	37.3
3	Хүчингүй болгосон	112	126	14	12.5
	НИЙТ ДҮН	384	512	128	33.3

Шийдвэрийн чанар, тогтвортой байдал: Өмнөх онтой харьцуулбал Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлал 86 буюу 43.65 хувиар, шийдвэрт өөрчлөлт оруулсан магадлал 28 буюу 37.33 хувиар, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын тоо 12.5 хувиар тус тус өссөн байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн хэрэг өмнөх онтой харьцуулахад 43.65 хувиар өссөн байгаа нь анхан шатны шүүхийн шийдвэр чанаржиж, тогтвортой болж байгааг харуулж байна.

Өөрчлөлт оруулсан: 2014 онд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан нийт 103 хэргийн 53 буюу 51 хувьд “хууль буруу хэрэглэсэн”, 50 буюу 49 хувьд “нотлох баримтыг буруу үнэлсэн” гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулжээ. /График 4.5/

График 4.5

Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан үндэслэл



Хүчингүй болгосон: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2014 онд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон нийт 126 хэргийн 65 буюу 51.6 хувийг анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцааж, 28 буюу 22.2 хувьд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 24 буюу 19 хувьд нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүхэлд нь хангаж, 6 буюу 4.8 хувьд нь хэргийг хэрэгсэхгүй болгож, 3 хэрэгт буюу 2.4 хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. /Хүснэгт 4.8/

Хүснэгт 4.8

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл

Д/д	Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл	Бүтэн жил		Өсөлт, бууралт		Хүчингүй болсон хэрэгт эзлэх хувь	
		2013 он	2014 он	Тоо	Хувь	2013 он	2014 он
1	Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	26	28	2	7.69	23.2	22.2
2	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	4	6	2	50.00	3.6	4.8
3	Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүхэлд нь хангасан	17	24	7	41.18	15.2	19.0
4	Анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан	64	65	1	1.56	57.1	51.6
5	Хэргийг харьяалагдах шүүхэд шилжүүлсэн	0	0	0	-	0	0
6	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан	1	3	2	3 дахин	0.9	2.4
НИЙТ ДҮН		112	126	14	12.5	100	100

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2014 онд анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан нийт 65 хэргээс 59 буюу 85.71 хувь нь нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн гэх үндэслэлээр буцаан шийдвэрлэсэн нь захиргааны хэргийн анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргахыг шаардах, цуглуулах, үнэлэх ажлын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна. /Хүснэгт 4.9/

Хүснэгт 4.9

Хэргийг анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл

Д/д	Үндэслэл	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
1	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	3	0	-3	-100
2	Нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн	47	59	12	25.53
3	Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	0	1	1	-
4	Хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг үндэслэсэн	4	0	-4	-100
5	ЗХХШТХ зөрчсөн нь шийдвэр гаргахад нөлөөлсөн	9	4	-5	-55.56
6	Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй	0	0	0	-
7	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн	1	1	0	-

4.3. Хяналтын шатны шүүх

Улсын дээд шүүх 2014 онд нийт 393 захиргааны хэрэг хүлээн авснаас 381 хэргийг шийдвэрлэж тайлант хугацааны эцсийн байдлаар 12 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хянан шийдвэрлэсэн нийт 381 хэргээс 300 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 40 хэрэгт албан бичгээр хариу өгч, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан 27 хэргийг шийдвэрлэж, “хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын гомдлоосоо татгалзсан”, “хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрсэн буюу тооцох боломжгүй” зэрэг үндэслэлээр нийт 14 хэргийг шүүх хуралдаанд оруулалгүйгээр шийдвэрлэсэн байна. /Хүснэгт 4.10/

Хүснэгт 4.10

Хяналтын шатны шүүхийн шийдвэр

Д/д	Утга	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
	Нийт хүлээн авсан хэрэг	329	393	64	19.45
1	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	245	300	55	22.45
2	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан хэргийг шийдвэрлэсэн байдал	19	27	8	42.11
3	Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж албан бичгээр хариу өгсөн	44	40	-4	-9.09
4	Хяналтын журмаар гомдол гаргах хугацаа хэтэрсэн буюу тооцох боломжгүй	0	2	2	-
5	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын гомдлоосоо татгалзсан	4	4	0	-
6	Бусад	0	8	8	-
7	Үлдэгдэл хэрэг	17	12	-5	-29.41

Өмнөх онтой харьцуулахад хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг 22.4 хувиар, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан хэргийг шийдвэрлэсэн байдал 42.1 хувиар өссөн бол Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж албан бичгээр хариу өгсөн хэрэг 9.1 хувиар буурчээ.

Хяналтын шатны шүүх 2014 онд нийт хүлээж авсан хэргийн 76.3 хувь буюу 300 хэргийг шүүх хуралдаанаар, 10.17 хувь буюу 40 хэрэгт Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж албан бичгээр хариу өгч, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан 6.8

хувь буюу 27 хэргийг шийдвэрлэж, 3.5 хувь буюу 14 хэргийг шүүх хуралдаанд оруулалгүйгээр тус тус шийдвэрлэж тайлангийн эцсийн үлдэгдэл 12 хэрэг байна.

Улсын тэмдэгтийн хураамжийг хуульд заасан журмын дагуу төлөөгүй, Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн хэрэг байхгүй байна.

2014 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэгдсэн нийт 300 хэргийн 212 буюу 70.6 хувьд шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон, 34 буюу 11.33 хувьд нь шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан, 25 буюу 8.3 хувьд нь шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн, 9 хэрэгт буюу 3 хувьд шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, 20 хэрэгт буюу 6.6 хувьд нь шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ. /Хүснэгт 4.11/

Хүснэгт 4.11		Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн төрөл (Өмнөх онтой харьцуулсан)			
Д/д	Шийдвэрийн төрөл	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2013 он	2014 он	Тоо	Хувь
	Нийт шийдвэрлэсэн хэрэг	245	300	55	22.45
1	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон	175	212	37	21.14
2	Шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулсан	24	34	10	41.67
3	Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн	16	25	9	56.25
4	Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон	0	0	0	-
5	Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	4	9	5	2.25
6	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	26	20	-6	-23.08

Дахин хэлэлцүүлэхээр буцаасан 20 хэргийг ЗХХШТХ-ийн 30, 31 дүгээр зүйлд заасан шүүх захиргааны хэргийг нотлох үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр буцааснаас үзвэл захиргааны хэргийн шүүх мөрдөн шалгах зарчмыг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

ТАВ. ШҮҮН ТАСЛАХ БУСАД АЖИЛЛАГАА

5.1. Сэжигтнийг баривчлах, арга хэмжээ

Монгол Улсын шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 869 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 814 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 55 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Баривчлах зөвшөөрөл олгосон нийт хүмүүсийн 2.8 хувийг насанд хүрээгүй хүмүүс, 5.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүмүүсийн 14.5 хувийг “гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримтгүй”, 47.2 хувийг “цагдан хорих арга хэмжээ авах үндэслэлгүй”, 25.4 хувийг “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлийг зөрчсөн” гэсэн үндэслэлээр суллажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулбал 312 хүнээр буюу 26.4 хувиар буурсан байна. Баривчлах арга хэмжээ авсан хүмүүсээс насанд хүрээгүй хүний тоо өнгөрсөн оноос 17 хүн буюу 42.5 хувиар буурсан бол баривчлах зөвшөөрөл олгосон эмэгтэйчүүдийн тоо 5 хүнээр буюу 12.1 хувиар өссөн байна. /Хүснэгт 5.1/

Хүснэгт 5.1

Сэжигтнийг баривчлах арга хэмжээ


Д.д	Утга	2013 он	2014 он
1.	Баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоо	1181	869
	Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо	1054	814
2.	Насанд хүрээгүй хүн	40	23
	Эмэгтэй	41	46
	Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо	127	55
3.	Гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримтгүй	14	8
	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлгүй	62	26
	ЭБШХуулийн 58 дугаар зүйлийг зөрчсөн	11	14

Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо өнгөрсөн оноос 240 хүн буюу 22.7 хувиар буурсан /График 5.1/ бол баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 72 хүн буюу 56.6 хувиар мөн буурчээ. /График 5.2/

График 5.1



График 5.2



5.2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2014 онд шүүхээс 1815 хүнийг сэжигтнээр, 1906 хүнийг яллагдагчаар цагдан хорих шийдвэр гаргажээ. Нийт 3721 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгосноос 106 буюу 2.8 хувь нь насанд хүрээгүй, 176 буюу 4.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 5.2.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан тухай мэдээ


Утга	2013 он	2014 он
1. Цагдан хорих зөвшөөрөл олгосон хүний тоо	3610	3721
2. Сэжигтэн	1989	1815
3. Яллагдагч	1621	1906
4. Насанд хүрээгүй хүн	132	106
5. Эмэгтэй	151	176

Шүүхээс цагдан хорих зөвшөөрөл олгосон хүний тоо 2013 оноос 111 хүн буюу 3.0 хувиар өссөн үзүүлэлттэй байх бөгөөд цагдан хорих арга хэмжээ авсан сэжигтний тоо 174 хүнээр буюу 8.7 хувиар буурсан бол яллагдагчийн тоо 285 хүнээр буюу 17.6 хувиар өсчээ. Түүнчлэн цагдан хорих арга хэмжээ авсан насанд хүрээгүй хүний тоо 26 буюу 19.7 хувиар буурсан бол эмэгтэйчүүдийн тоо 25 хүн буюу 16.6 хувиар өсчээ.

Цагдан хорих зөвшөөрөл олгосон үндэслэлээс 1512 буюу 42 хувийг “оргон зайлж болзошгүй”, 1441 буюу 40 хувийг “хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн” гэсэн үндэслэл эзэлж байгаа нь цагдан хорих арга хэмжээ авсан үндэслэл дийлэнх хувийг эзэлж байна.

График 5.3

Цагдан хорих зөвшөөрөл олгосон үндэслэл



Баривчлах, цагдан хорих талаар гаргасан шүүгчийн захирамж: 2014 онд баривчлах, цагдан хорих талаар нийт 9835 шүүгчийн захирамж гарсан байна. Үүнээс сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай 3870 захирамж, цагдан хорих хугацааг сунгах тухай 3228 захирамж гарсан нь нийт захирамжийн 72.1 хувийг эзэлж байна. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай 1361, сэжигтнийг баривчлах тухай 375 захирамж гарсан нь нийт захирамжийн 17.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5.3

Баривчлах, цагдан хорих талаар гаргасан шүүгчийн захирамж

№		Шүүгчийн захирамж	2013 он	2014 он
1		Нийт	11099	9835
2		Сэжигтнийг баривчлах тухай	542	375
3		Сэжигтнийг баривчлахаас татгалзах тухай	50	42
4		Сэжигтнийг суллах тухай	67	82
5		Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай	3603	3870
6		Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	238	225
7		Сэжигтэн, яллагдагчийг өөр газар шилжүүлэн цагдан хорих тухай	124	110
8	Үүнээс:	Сэжигтэн, яллагдагчийг өөр газар шилжүүлэн цагдан хорихоос татгалзах тухай	4	0
9		Цагдан хорих хугацааг сунгах тухай	3681	3228
10		Цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай	98	114
11		Шүүхэд хянагдаж буй яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай	139	113
12		Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	41	85
13		Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	1368	1361
14		Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжинд гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	214	230

5.3. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн тухай

2014 онд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 74, 75 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333, 334 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлолт, дүгнэлт ирүүлсэн нийт 2535 материалыг хянан хэлэлцсэнээс 29 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс

чөлөөлж, 1762 ялтныг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 627 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан бол 86 ялтны хорих ялын дэглэмийг хүндрүүлж шийдвэрлэсэн байна.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн тухай мэдээллийг өмнөх жилтэй харьцуулсан үзүүлэлт:

Хүснэгт 5.4

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн

Д/д	Утга	2013 он	2014 он
1.	ЭХ-ийн 74, 75, ЭБШХ-ийн 333,334-р зүйлд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо	2497	2535
2.	Өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн	33	29
3.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан	1627	1762
4.	Үлдсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольсон	11	0
5.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө үлдсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай санал, дүгнэлтийг хэрэгсэхгүй болгосон хүний тоо	46	33
6.	Хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан бүгд	570	627
7.	Хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлсэн бүгд	129	86


Эрүүгийн хуулийн 74, 75, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333, 334 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоог 2013 онтой харьцуулбал 38 хүнээр буюу 1.5 хувиар өссөн байна. Өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн хүний тоо өнгөрсөн оноос 4 хүнээр буурсан байна.

Улсын хэмжээнд 2014 онд нийт 627 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан нь 2013 онтой харьцуулбал 57 хүн буюу 10.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (График 5.4) Мөн хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан хүний тоо 135 хүнээр буюу 8.3 хувиар өссөн байна. (График 5.5)

График 5.4



График 5.5



5.4. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн талаар

Улсын хэмжээнд 2014 онд 18859 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс 18611 зөрчилд захиргааны хариуцлага ногдуулж, 248 тохиолдолд татгалзаж буцаасан байна. Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл ногдуулсан 298 шийдвэрийг хянаснаас 219 буюу 73.4 хувьд нь хэвээр үлдээж, 58 буюу 19.4 хувьд нь өөрчлөлт оруулж, 21 буюу 7.0 хувийг хүчингүй болгожээ. /Хүснэгт 5.5/

Хүснэгт 5.5

Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн мэдээлэл

Д/д	Утга	2013 он	2014 он
1	Бүгд	16725	18859
2	Захиргааны арга хэмжээ авагдсан бүгд	16475	18611
3	Арга хэмжээ авахаас татгалзаж буцаасан	250	248
4	Торгуулсан бүх хүн	623	754
5	Торгуулсан эмэгтэй	98	150
6	Нийт торгуулийн хэмжээ /мян.төг/	12869400	133334000
7	Баривчилсан бүгд	15850	17857
8	Баривчлагдсан эмэгтэй	415	467
9	Үлдэгдэл	1	0
Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн			
1	Бүгд	263	298
2	Хэвээр үлдээсэн	186	219
3	Өөрчлөгдсөн	59	58
4	Хүчингүй болсон	20	21

Улсын хэмжээнд торгох арга хэмжээ авсан хүмүүсийн 4.05 хувийг, нийт баривчлагдсан хүмүүсийн 2.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн захиргааны зөрчлийн тоо 12.8 хувиар өссөн байна. /График 5.6/ Үүнээс захиргааны хариуцлага оногдуулсан нийт хүний тоо өнгөрсөн онд 16475 байсан бол 2014 онд 18611 болж 13.0 хувиар өссөн байна. Харин баривчлагдсан эмэгтэйчүүдийн тоо 52 хүн буюу 12.5 хувиар өссөн байна. /График 5.7/

График 5.6



График 5.7




Мөн торгох захиргааны шийтгэл оногдуулсан эмэгтэйчүүдийн тоо өнгөрсөн онд 98 байсан бол 2014 онд 150 болж 53.1 хувиар өсчээ.

Захиргааны арга хэмжээ авахаас татгалзаж, буцаасан тохиолдол өнгөрсөн онд 250 байсан бол 2014 онд 248 болж 0.8 хувиар буурсан байна. /График 5.8/ Торгуулсан бүх хүний тоо өнгөрсөн онд 623 байсан бол 2014 онд 754 болж 21 хувиар өссөн байна. /График-5.9/ Нийт торгуулийн хэмжээ өнгөрсөн онд 12.869.400 төгрөг байсан бол 2014 онд 13.134.000 төгрөг болж 2 хувиар өссөн байна.

График 5.8



График 5.9



Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн тоо өнгөрсөн онд 263 байсан бол 2014 онд 298 болж 13.3 хувиар өссөн байна. Өнгөрсөн онд захиргааны шийтгэл оногдуулсан 263 шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 186 буюу 70.7 хувийг хэвээр үлдээж, 59 буюу 22.4 хувьд өөрчлөлт оруулж, 20 буюу 7.6 хувийг хүчингүй болгож байсан бол 2014 онд 298 шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 219 буюу 73.4 хувийг хэвээр үлдээж, 58 буюу 19.4 хувьд өөрчлөлт оруулж, 21 буюу 7.0 хувийг хүчингүй болгосон байна.

Баривчлах захиргааны шийтгэл оногдуулсан нийт хүний тоо өнгөрсөн онд 15850 байсан бол 2014 онд 17857 болж 2007 хүн буюу 12.7 хувиар өссөн байна.

ЗУРГАА. ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА


Улсын хэмжээнд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид 2014 онд нийт 6427 нэхэмжлэл, өргөдөл хүлээн авчээ. Үүнээс шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл 6143, шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл 65, шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн иргэний хэрэг 219 байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 6143 өргөдлөөс 346 өргөдлийг журмын дагуу хүлээн авахаас татгалзаж, 308 өргөдлийг хүсэлт гаргагч өөрийн хүсэлтээр эргүүлэн авч, 5122 өргөдлийг шийдвэрлэж, 367 өргөдлийн үлдэгдэлтэй байна. /График 6.1/

Шийдвэрлэсэн 5122 өргөдлөөс 2847 буюу 55.5 хувьд нь эвлэрэл амжилттай болж, 2275 буюу 44.5 хувьд нь эвлэрэл амжилтгүй болсон байна.

График 6.1

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл



Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн 65 нэхэмжлэлээс 62 нь эвлэрэл амжилттай болж 3 хэргийн үлдэгдэлтэй байна. /График 6.2/ Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн 219 иргэний хэргээс 61 нь эвлэрэл амжилттай болж, 141 нь эвлэрэл амжилтгүй болсон. Тайлант жилийн эцсийн үлдэгдэл 17 хэрэг байна. /График 6.3/

График 6.2

Хэрэг үүсэхээс өмнө





График 6.3

Хэрэг үүссэний дараа



ДОЛОО. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний хэрэг: Шүүхээс 2014 онд улсын тэмдэгтийн хураамжид (32890) нийт 7 тэрбум 138 сая 566 мянга 641 төгрөгийг төрийн санд оруулсан байна. /График 7.1/




Анхан шатны шүүхийн 30848 нэхэмжлэлийн 6 тэрбум 608 сая 687 мянга 715 төгрөг, давж заалдах шатны шүүхийн 1452 нэхэмжлэлийн 296 сая 667 мянга 136 төгрөг, хяналтын шатны шүүхийн 590 нэхэмжлэлийн 233 сая 211 мянга 790 төгрөгийг төрийн санд оруулсан байна.

Улсын хэмжээнд 2014 онд 3742 нэхэмжлэлд хамаарах 562 сая 236 мянга 660 төгрөгийг хуульд заасны дагуу тэмдэгтийн хураамжаас чөлөөлж, 50 нэхэмжлэлд 1 сая 40 мянга 541 төгрөгөөр улсын тэмдэгтийн хураамжийг багасгасан байна.

Нийт 6584 нэхэмжлэлд хамаарах 1 тэрбум 648 сая 469 мянга 197 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг хуульд заасны дагуу буцаан олгосон байна.

Захиргааны хэрэг: Шүүхээс 2014 онд нийт 1693 тэмдэгтийн хураамжид хамаарах 118 сая 848 мянга 600 төгрөг төрийн санд оруулсан байна. /График 7.2/



Анхан шатны 1241 нэхэмжлэлийн 87 сая 118 мянга 200 төгрөг, давж заалдах шатны шүүхийн 292 нэхэмжлэлийн 20 сая 498 мянга 400 төгрөг, хяналтын шатны 160 нэхэмжлэлийн 11 сая 232 мянган төгрөгийг төрийн санд оруулсан байна. Мөн 117 нэхэмжлэлд хамаарах 8 сая 213 мянга 400 төгрөгийг тэмдэгтийн хураамжаас хуульд заасны дагуу чөлөөлж, багасгасан байна.

Тайлант хугацаанд анхан шатны шүүхийн 148 нэхэмжлэлийн 9 сая 828 мянган төгрөг, давж заалдах шатны шүүхийн 33 нэхэмжлэлийн 2 сая 597 мянга 400 төгрөг, хяналтын шатны 13 нэхэмжлэлийн 912 мянга 600 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг буцаан олгосон байна.

Эрүүгийн хуульд заасан торгох ялаар 285 хүнийг нийт 1 тэрбум 477 сая 241 мянга 600 төгрөгийн торгох ял ногдуулсан байна. Захиргааны зөрчлийн улмаас 754 хүнд 13.134.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Монгол Улсын шүүхээс 2014 онд улсын тэмдэгтийн хураамжаар 7 тэрбум 257 сая 415 мянга 241 төгрөг, торгох ялаар 1 тэрбум 477 сая 421 мянга 600 төгрөг, захиргааны зөрчлийн торгох хариуцлагын арга хэмжээгээр 13 сая 134 мянган төгрөг, эд хөрөнгө хураах ялаар 350 сая 563 мянга 666 төгрөг нийт 9 тэрбум 98 сая 354 мянга 507 төгрөгийг төрийн санд оруулсан байна.

НАЙМ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нийт шийдвэрлэсэн хэрэг, маргаан: Монгол Улсын шүүх 2014 онд эрүүгийн 6375 хэрэг, иргэний 33996 хэрэг, захиргааны 1187 хэрэг, нийт 41558 хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 1031 хэргээр буюу дунджаар 2.4 хувиар буурсан байна. Шүүн таслах ажиллагааны төрлөөр авч үзвэл анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 3.3 хувиар, захиргааны хэрэг 7.3 хувиар тус тус өссөн бол иргэний хэрэг 3.7 хувиар буурчээ. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оноос буурсан нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж, анхан шатны шүүхүүд дэх эвлэрүүлэн зуучлагчид 6143 өргөдлийг хүлээн авч, 5122 хэрэг, маргааныг шийдвэрлэсэнтэй холбоотой юм.

Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргээс хүнийг санаатай алах гэмт хэрэг 1.9 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10.8 хувиар, танхайрах гэмт хэрэг 13.5 хувиар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 15.5 хувиар тус тус буурсан бол бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 20.7 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 12 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 20.7 хувиар тус тус өссөн байна. Хүч хэрэглэсэн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна.

Анхан шатны шүүх 2014 онд 33996 иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 1318 хэргээр буюу 3.7 хувиар буурсан байна. Иргэний эрх зүйн нийт шийдвэрлэсэн хэргээс Иргэний хуулиар шийдвэрлэсэн 14708 хэрэг буюу 43.3 хувийг, ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн

12421 хэрэг буюу 36.5 хувийг, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн 4207 хэрэг буюу 12.4 хувийг, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн 1377 хэрэг буюу 4.05 хувийг тус тус эзэлжээ.

Иргэний эрх зүйн хэрэг, маргааны төрлийн хувьд иргэний эрх зүйн маргаан 1970 хэргээр буюу 15.47 хувиар, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 297 хэргээр буюу 27.5 хувиар, газрын эрх зүйн маргаан 39 хэргээр буюу 41.94 хувиар тус тус өссөн бол ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн маргаан 3150 хэргээр буюу 20.2 хувиар, гэр бүлийн эрх зүйн маргаан 69 хэргээр буюу 1.61 хувиар, Компанийн тухай хуулиар шийдвэрлэсэн маргаан 10 хэргээр буюу 55.6 хувиар тус тус буурчээ.

Захиргааны хэргийн хувьд иргэний бүртгэлтэй холбоотой маргаан өмнөх онтой харьцуулбал 2.2 дахин, төрийн хяналт, шалгалттай холбоотой бусад маргаан 76.09 хувиар, төрийн албаны маргаан 46.31 хувиар, газрын маргаан 37.86 хувиар, татварын маргаан 24.62 хувиар тус тус өссөн дүнтэй байгаа бол сонгуулийн маргаан 86.41 хувиар, ашигт малтмалтай холбоотой маргаан 40.28 хувиар, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан 32.95 хувиар тус тус буурсан байна.

Анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн үлдэгдэл өмнөх оноос 12.3 хувиар буурсан бол иргэний хэргийн үлдэгдэл 22.7 хувиар, захиргааны хэргийн үлдэгдэл 13.37 хувиар тус тус өссөн дүн гарав.

Давж заалдах шатны шүүх 2014 онд эрүүгийн 2161, захиргааны 883, иргэний 1947 хэрэг, нийт 4991 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулбал 13.6 хувиар өсчээ. Шүүн таслах ажиллагааны төрлөөр авч үзвэл давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг 10.3 хувиар, иргэний хэрэг 6.8 хувиар, захиргааны хэрэг 41.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн үлдэгдэл өмнөх оноос 47.9 хувиар, иргэний хэргийн үлдэгдэл 7.8 хувиар, захиргааны хэргийн үлдэгдэл 19.35 хувиар тус тус буурсан байна.

Хяналтын шатны шүүх 2014 онд эрүүгийн 629, иргэний 1017, захиргааны 381 хэрэг нийт 2027 хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг 3.5 хувиар, захиргааны хэрэг 42.2 хувиар тус тус өссөн бол эрүүгийн хэрэг өмнөх оноос 8.2 хувиар буурчээ.

Ял шийтгүүлсэн байдал: Монгол Улсын хэмжээнд 2014 оны байдлаар нийт 8178 хүн анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн нь өмнөх онтой харьцуулбал ял шийтгүүлэгчдийн тоо 113 хүнээр буюу 1.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Ялын төрлөөр авч үзвэл шүүхээс баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 1.8 хувиар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 2.1 хувиар, тодорхой албан

тушаал эрхлэх эрхийг хасах ялаар шийтгүүлсэн хүний тоо 2.6 дахин тус тус өссөн бол тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялаар шийтгүүлсэн хүний тоо 3.9 хувиар, албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний тоо 5.2 хувиар, торгох ял шийтгүүлсэн хүний тоо 3.4 хувиар тус тус буурсан байна.

Нийт ял шийтгүүлэгчдээс (давхардсан тоогоор) урьд ял шийтгүүлж байсан хүмүүсийн тоо өмнөх оноос 221 хүн буюу 13 хувиар, бүлэглэж үйлдсэн хүний тоо 190 буюу 13.4 хувиар, эмэгтэйчүүдийн тоо 26 буюу 3.8 хувиар тус тус өссөн бол насанд хүрээгүй хүний тоо 98 буюу 17.3 хувиар буурсан байна. Энэ нь өмнө ял шийтгэгдсэн хүмүүсийг нийгэмшүүлэх, дэмжлэг үзүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Ял шийтгүүлэгчдийн дундаас насанд хүрээгүй хүмүүсийн тоо буурсан эерэг дүнтэй байгаа боловч эмэгтэйчүүдийн тоо өсөх хандлагатай байна.

Ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр нь авч үзвэл 14-15 настай ял шийтгүүлэгчийн тоо өмнөх онтой харьцуулбал 34.9 хувиар буурсан нь эерэг үзүүлэлт хэдий ч насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг цаашид улам эрчимжүүлэх шаардлагатай юм.

Ял шийтгүүлэгчдийг боловсролын түвшингээр нь ангилж үзвэл дээд боловсролтой ял шийтгүүлэгчид өмнөх оноос 15 хувиар, боловсролгүй ял шийтгүүлэгчид 4.8 хувиар өссөн бол эрхэлсэн ажил, сургуульгүй ял шийтгүүлэгчид 1.3 хувиар өсчээ. Боловсролгүй, эрхэлсэн ажил сургуульгүй ял шийтгүүлэгчдийн тоо өсч байгаа нь нийгэмд ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зорилтот бүлгийн онцлогт нийцсэн арга, хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

8.1. Шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдал

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2014 онд шийдвэрлэсэн нийт хэргийн 35.3 хувьд нь давж заалдсан байна. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 29.9 хувьд нь хяналтын шатны шүүхэд гомдол гаргажээ.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2014 онд шийдвэрлэсэн нийт хэргийн 6.2 хувьд нь зохигчид давж заалдсан. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 53.9 хувьд нь хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж ханджээ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2014 онд шийдвэрлэсэн нийт хэргийн 78.6 хувьд нь хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч давж заалдсан бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 44.5 хувьд нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч хяналтын шатны шүүхэд хандсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал давж заалдах шатны журмаар гомдол гаргасан хэргийн нийт хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт эзлэх хэмжээ 1.7 хувиар буурсан бол иргэний хэргийн давж заалдсан хэргийн эзлэх хэмжээ 0.5 хувиар, захиргааны хэргийн давж заалдсан хэргийн эзлэх хэмжээ 18.9 хувиар тус тус өссөн дүнтэй гарав.

Өнгөрсөн онтой харьцуулбал хяналтын шатанд хандсан Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд эзлэх хэмжээ 5.4 хувиар, иргэний хэргийн хяналтын шатанд хандсан хэргийн эзлэх хэмжээ 2.1 хувиар, захиргааны хэргийн хяналтын шатанд хандсан хэргийн эзлэх хэмжээ 10.5 хувиар тус тус буурсан байна.

а. Эрүүгийн хэрэг: Давж заалдах шатны шүүхээс 2014 онд анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээсэн нь нийт магадлалын 46.5 хувийг, тогтоолд өөрчлөлт оруулсан нь 22 хувийг, тогтоолыг хүчингүй болгосон нь 31.3 хувийг тус тус эзэлж байна. Анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээсэн магадлалын эзлэх хэмжээ өмнөх оноос 5.1 хувиар буурсан бол тогтоолд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ 2.1 хувиар, тогтоолыг хүчингүй болгосон магадлалын эзлэх хэмжээ 2.9 хувиар тус тус өссөн дүнтэй гарсан байна.

Шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн үндэслэлийг өмнөх онтой харьцуулахад “тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй” гэсэн үндэслэл 17.4 хувиар, “ЭБШ хуулийг ноцтой зөрчсөн” гэсэн үндэслэл 25.3 хувиар тус тус өсчээ. Иймд анхан шатны шүүхийн түвшинд нотлох баримтыг цуглуулах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар цаашид анхаарах шаардлагатайг харуулж байна. Мөн шүүхийн сургалтын хөтөлбөрт дээрх асуудлыг голчлон тусгах нь зүйтэй юм.

Хяналтын шатны шүүхийн 2014 оны нийт шийдвэрээс үзвэл шүүхийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шийдвэр 57 хувийг, тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан шийдвэр 22 хувийг, тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн шийдвэр 21 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн шийдвэрийн эзлэх хэмжээ 3 хувь, тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан шийдвэрийн эзлэх хэмжээ 28.6 хувиар тус тус өссөн бол тогтоол, магадлалыг хүчингүй болгосон шийдвэрийн эзлэх хэмжээ 45.4 хувиар буурсан байна.

Хяналтын шатны шүүхээс шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон үндэслэлийг авч үзвэл 76 хувийг тогтоол, магадлалд дурдсан “хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй” гэсэн үндэслэл, 24 хувийг “ЭБШ хуулийг ноцтойгоор зөрчсөн” гэсэн үндэслэл эзэлж байна. Иймд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн хууль хэрэглээний

чадварыг дэмжих, шүүгчдийг процессын алдаа гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

6. Иргэний хэрэг: Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлал 79 хэргээр буюу 9.6 хувиар буурсан бол өөрчлөлт оруулсан магадлал 101 хэргээр буюу 20.5 хувиар, хүчингүй болгосон магадлал 119 хэргээр буюу 24.1 хувиар тус тус өсчээ. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хэвээр үлдээсэн тоо буурч, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь анхан шатны шүүхийн шийдвэрийн чанар хангалттай бус байгааг харуулж байна.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг ИХШХШТХ-ийн 38.6-д зааснаар “нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн” гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон хэрэг 16.3 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 41.5 хувиар буурсан байна. Түүнчлэн “хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон магадлалын тоо 22 хувиар өссөн байна. “Шүүх өөр хуулийг эсвэл хууль буруу тайлбарлан хэрэглэсэн” үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгосон магадлал өмнөх оноос 52 хувиар өссөн анхан шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхдээ ИХШХШТХ-ийн журам зөрчих, хуулийг зөв тайлбарлаж хэрэглэх, зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангах шаардлагатай юм.

Хяналтын шатны шүүх 2014 онд 841 хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэснээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон хэргийн тоо 38 хэргээр буюу 8.2 хувиар, шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан хэргийн тоо 32 хэргээр буюу 32 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн хэргийн тоо 35 хэргээр буюу 64.8 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 3 хэргээр буюу 37.5 хувиар тус тус өсчээ. Харин шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 1 хэргээр буюу 20 хувиар, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэргийн тоо 25 хэргээр буюу 19.7 хувиар тус тус буурсан байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нийт хэрэгт “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж, хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 49 хэрэг буюу 48 хувийг, “Шүүх өөр хуулийг эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл 33 хэрэг буюу 32.4 хувийг тус тус эзэлсэн байна.

в. Захиргааны хэрэг: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлалын тоо нийт магадлалын 55 хувийг, өөрчлөлт оруулсан магадлал 20 хувийг, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон магадлал 25 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулбал хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ 43.65 хувиар өссөн нь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр чанаржиж, тогтвортой болж байгааг харуулж байна. Өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ өмнөх оноос 37.33 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын хэмжээ 12.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Шүүхийн шийдвэрийг “нотлох баримтыг буруу үнэлсэн” гэх үндэслэлээр өөрчлөлт оруулсан нь 49 хувьтай буюу өмнөх онтой харьцуулбал 2.2 дахин өссөн байгаа бол “хууль буруу хэрэглэсэн” гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулсан үндэслэл 51 хувьтай буюу өмнөх оноос 1.92 хувиар өссөн байна.

“Шүүх нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн” үндэслэлээр буцаах, шүүхээр дахин хэлэлцүүлэх тохиолдол өссөн нь захиргааны хэргийн шүүх ЗХХШТХ-д заасан “хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүрэг”-ийг хангалтгүй гүйцэтгэж байгаатай холбоотой гэж үзэхээр байна. Иймд захиргааны хэргийн шүүгчдийг нотлох баримтыг үнэлж, дүгнэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалтанд түлхүү хамруулах шаардлагатай байна.

Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн шийдвэр өмнөх оноос 37 хэргээр буюу 21.1 хувиар, түүнчлэн шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан нь 10 хэргээр буюу 41.7 хувиар тус тус өссөн бол шийдвэр магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн нь 9 хэргээр буюу 56.3 хувиар өссөн байна. Харин хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэг өмнөх оноос 6 хэргээр буюу 23.1 хувиар буурсан нь эерэг үзүүлэлт юм.

Шүүн таслах бусад ажиллагаа

Сэжигтнийг баривчлах арга хэмжээ: Улсын хэмжээнд 2014 онд Эрүүгийн хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр шүүхэд нийт 869 сэжигтнийг баривчлах материал хүлээн авснаас 814 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 55 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан байна. Сэжигтнийг баривчлах тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулбал 312 хүнээр буюу 26.4 хувиар, харин баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 240 хүнээр буюу 22.8 хувиар тус тус буурсан байна. Үүнээс баривчлах зөвшөөрөл олгосон

насанд хүрээгүй этгээдийн тоо 17 хүнээр буюу 42.5 хувиар буурсан бол эмэгтэйчүүдийн тоо 5 хүнээр буюу 12.1 хувиар өсчээ.

Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо өмнөх онтой харьцуулахад 72 хүнээр буюу 56.7 хувиар буурсан байна. Үүнд “гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримтгүй” гэсэн үндэслэлээр татгалзсан хүний тоо 6 хүнээр буюу 42.9 хувиар буурсан, “цагдан хорих арга хэмжээ авах үндэслэлгүй” гэсэн үндэслэлээр сулласан хүний тоо 36 хүнээр буюу 58 хувиар буурсан зэрэг үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

Цагдан хорих арга хэмжээ: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу шүүхээс нийт 3721 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгосноос 1815 хүн буюу 48.8 хувийг сэжигтнээр, 1906 хүн буюу 51.2 хувийг яллагдагчаар тус тус цагдан хорих зөвшөөрөл олгожээ. Улсын хэмжээнд 2014 онд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан хүний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал 111 хүнээр буюу 3.1 хувиар өссөн хэдий ч насанд хүрээгүй этгээдийг цагдан хорьсон тоо 26 хүнээр буюу 19.7 хувиар, эмэгтэйчүүдийн тоо 25 хүн буюу 16.6 хувиар тус тус буурсан нь “эерэг” үзүүлэлт гэж үзэж байна.

Цагдан хорих зөвшөөрөл олгосон үндэслэлээс 1512 буюу 42 хувийг “оргон зайлж болзошгүй”, 1441 буюу 40 хувийг “хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн” гэсэн үндэслэл эзэлж байгаа нь цагдан хорих арга хэмжээ авсан үндэслэл дийлэнх хувийг эзэлж байна.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 74, 75 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333, 334 дүгээр зүйлд тус тус заасны дагуу 2014 онд шүүхэд нийт 2535 хүнд холбогдох тодорхойлолт, дүгнэлт ирүүлснээс 29 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлж, 1762 ялтныг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 627 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулж, 86 ялтны дэглэмийг хүндрүүлж шийдвэрлэжээ.

Өнгөрсөн онтой харьцуулбал эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт үйлдэж ирүүлсэн хүний тоо 38 хүнээр буюу 1.5 хувиар өссөн дүнтэй байна. Өвчний учир хугацааны өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн ялтны тоо 4 хүнээр буюу 12.1 хувиар буурсан бол хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан хүний тоо 135 хүнээр буюу 8.3 хувиар, хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан ялтны тоо 57 хүнээр буюу 10 хувиар тус тус өсчээ.

Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тухай: 2014 онд улсын хэмжээнд шүүхэд нийт 18859 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс 18611 зөрчилд захиргааны хариуцлага ногдуулж, 248 тохиолдолд захиргааны зөрчил ногдуулахаас татгалзаж буцаажээ. Өнгөрсөн онтой

харьцуулбал бүртгэгдсэн захиргааны зөрчлийн тоо 12.8 хувиар өссөн бол захиргааны хариуцлага хүлээлгэхээс татгалзсан тохиолдол 0.8 хувиар буурсан байна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа: Иргэд, хуулийн этгээд 2014 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар 6143 өргөдөл гаргаснаас 5122 маргааныг эвлэрүүлэн зуучлагч нар шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 2847 маргаан буюу 55.6 хувьд нь эвлэрэл амжилттай болсон бол 2275 маргаан буюу 44.4 хувьд нь эвлэрэл амжилтгүй болжээ. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжаар улсын төсөвт 105 сая 401 мянга 268 төгрөгийг улсын тэмдэгтийн хураамж байдлаар төвлөрүүлсэн байна.

Шүүхийн үйлчилгээ: Торгох захиргааны хариуцлагын арга хэмжээ авсан хүний тоо өссөнтэй холбоотойгоор 2014 онд нийт торгуулийн хэмжээ 2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иргэний хэргийн анхан шатны шүүх 30848 нэхэмжлэлийн 6 тэрбум 608 сая 687 мянга 715 төгрөг, давж заалдах шатны шүүхийн 1452 нэхэмжлэлийн 296 сая 667 мянга 136 төгрөг, хяналтын шатны шүүхийн 590 нэхэмжлэлийн 233 сая 211 мянга 790 төгрөгийг төрийн санд оруулсан бол захиргааны хэргийн анхан шатны шүүх 1241 нэхэмжлэлийн 87 сая 118 мянга 200 төгрөг, давж заалдах шатны шүүхийн 292 нэхэмжлэлийн 20 сая 498 мянга 400 төгрөг, хяналтын шатны 160 нэхэмжлэлийн 11 сая 232 мянган төгрөгийг төрийн санд оруулсан байна.

8.2. Шүүгчийн хэргийн ачаалал

Сум дундын шүүх: Шүүгчийн хэргийн ачааллыг тооцохдоо тухайн шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийг шүүгчийн тоонд харьцуулж гаргасан бөгөөд 2014 онд Сум дундын 29 шүүхэд нийт 152 шүүгч ажилласан байна. Сум дундын шүүхийн хувьд 2014 онд нэг шүүгчид дунджаар 131 хэрэг ногдож байгаа бол Сум дундын 24 дүгээр шүүхэд (Увс аймаг) нэг шүүгчид 232 хэрэг, Сум дундын 27 дугаар шүүхэд (Хөвсгөл) нэг шүүгчид 176 хэрэг, Сум дундын 25 (Ховд, Жаргалант сум) болон 3 дугаар (Баянхонгор) шүүхэд нэг шүүгч 174 хэрэг шийдвэрлэсэн нь дунджаас харьцангуй их ачаалалтай байсан байна. Харин Сум дундын 16 (Өмнөговь, Ханбогд сум) дугаар шүүхэд нэг шүүгч 52 хэрэг, Сум дундын 6 дугаар (Говьсүмбэр) шүүхэд 65 хэрэг, 22 дугаар (Сэлэнгэ, Сайхан сум) шүүхэд 67 хэрэг, 29 дүгээр шүүхэд 71 хэрэг шийдвэрлэсэн нь дунджаас харьцангуй бага байгааг харуулж байна. /Хүснэгт 8.1/

Хүснэгт 8.1

		Шүүгчийн хэргийн ачаалал (Сумд дундын шүүх)				
Д/д	Шүүх	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Нийт хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Сум дундын 1 дүгээр шүүх	151	765	916	6	153
2	Сум дундын 2 дугаар шүүх	76	735	811	6	135
3	Сум дундын 3 дугаар шүүх	195	675	870	5	174
4	Сум дундын 4 дүгээр шүүх	116	633	749	5	150

5	Сум дундын 5 дугаар шүүх	63	430	493	5	99
6	Сум дундын 6 дугаар шүүх	46	215	261	4	65
7	Сум дундын 7 дугаар шүүх	254	1380	1634	10	163
8	Сум дундын 8 дугаар шүүх	99	488	587	4	147
9	Сум дундын 9 дүгээр шүүх	97	257	354	3	118
10	Сум дундын 10 дугаар шүүх	221	1004	1225	9	136
11	Сум дундын 11 дүгээр шүүх	88	365	453	4	113
12	Сум дундын 12 дугаар шүүх	59	569	628	5	126
13	Сум дундын 13 дугаар шүүх	32	318	350	4	88
14	Сум дундын 14 дүгээр шүүх	220	1152	1372	8	172
15	Сум дундын 15 дугаар шүүх	84	491	575	5	115
16	Сум дундын 16 дугаар шүүх	89	119	208	4	52
17	Сум дундын 17 дугаар шүүх	114	674	788	5	158
18	Сум дундын 18 дугаар шүүх	60	389	449	3	150
19	Сум дундын 19 дүгээр шүүх	133	503	636	5	127
20	Сум дундын 20 дугаар шүүх	134	669	803	6	134
21	Сум дундын 21 дүгээр шүүх	146	364	510	3	170
22	Сум дундын 22 дугаар шүүх	69	200	269	4	67
23	Сум дундын 23 дугаар шүүх	168	533	701	9	78
24	Сум дундын 24 дүгээр шүүх	113	815	928	4	232
25	Сум дундын 25 дугаар шүүх	62	633	695	4	174
26	Сум дундын 26 дугаар шүүх	15	290	305	4	76
27	Сум дундын 27 дугаар шүүх	226	1179	1405	8	176
28	Сум дундын 28 дугаар шүүх	135	563	698	6	116
29	Сум дундын 29 дүгээр шүүх	32	253	285	4	71
Нийт		3297	16661	19958	152	131

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд нийт 53 шүүгч ажиллаж байна. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд 2014 онд нэг шүүгчид дунджаар 58 хэрэг ногдож байна. Дүүргийн Эрүүгийн хэргийн 1 болон 2 дугаар шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал харьцангуй их байна.

Хүснэгт 8.2

Шүүгчийн хэргийн ачаалал (Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх)

Д/д	Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	1344	21	64
2	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	1488	24	62
3	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	108	4	27
4	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	138	4	34.5
Нийт		3078	53	58.1

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх: Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд нийт 65 шүүгч ажиллаж байна. Эдгээр шүүхэд 2014 онд нэг шүүгчид 267 хэрэг ногдож байна. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд шүүгчийн хэргийн ачаалал харьцангуй жигд байгаа бол Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн хэргийн ачаалал харьцангуй бага байна. /Хүснэгт 8.3/

Хүснэгт 8.3

Шүүгчийн хэргийн ачаалал (Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх)

Д/д	Шүүх	Иргэний хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	8005	28	286
2	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	7869	29	271
3	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	600	4	150
4	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	861	4	215
	Нийт	17335	65	267

Захиргааны хэргийн анхан шатны шүүх: Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд нийт 71 шүүгч ажиллаж байгаа бөгөөд 2014 онд нэг шүүгчид 17 хэрэг ногдож байна. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар (Улаанбаатар) шүүхэд нэг шүүгчид 58 хэрэг ногдож байгаа нь дунджаас 3 дахин их хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр (Архангай) шүүхэд 23 хэрэг ногдож байгаа нь захиргааны хэргийн орон нутгийн шүүхүүдээс хамгийн өндөр нь байгаа бол Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар (Өмнөговь) шүүхэд 3 хэрэг хянан шийдвэрлэж байгаа нь хамгийн бага байна. /Хүснэгт 8.4/

Хүснэгт 8.4

Шүүгчийн хэргийн ачаалал (Захиргааны хэргийн анхан шатны шүүх)

Д/д	Шүүх	Захиргааны хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэрэг
1	Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх	46	2	23.0
2	Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүх	39	3	13.0
3	Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүх	28	3	9.3
4	Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх	35	3	11.6
5	Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүх	10	3	3.3
6	Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүх	66	5	13.2
7	Захиргааны хэргийн анхан шатны 7 дугаар шүүх	18	3	6.0
8	Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүх	26	3	8.6
9	Захиргааны хэргийн анхан шатны 9 дүгээр шүүх	12	3	4.0
10	Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүх	22	3	7.3
11	Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүх	46	5	9.2
12	Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүх	8	3	2.6
13	Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүх	38	3	12.6
14	Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүх	13	3	4.3
15	Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүх	24	3	8.0
16	Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүх	36	3	12.0
17	Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүх	33	3	11.0
18	Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүх	29	3	9.6
19	Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүх	24	3	8.0
20	Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх	634	11	57.6
	Нийт	1187	71	16.7

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нийт 10 шүүгч ажиллаж байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2014 онд нийт 883 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд нэг шүүгчид дунджаар 88.3 хэрэг ногдож байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ачаалал: Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 шүүхэд нийт 51 шүүгч ажиллаж байна. Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн ачаалал улсын хэмжээнд нэг шүүгчид дунджаар 42 хэрэг ногдож байна. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх дунджаас 2 дахин их хэрэг шийдвэрлэж байгаа нь хамгийн өндөр байгаа бол Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5, 8 дугаар шүүх 12-13 хэрэг хянан шийдвэрлэсэн нь хамгийн бага юм. /Хүснэгт 8.5/

Хүснэгт 8.5		Шүүгчийн ажлын ачаалал (Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх)		
Д/д	Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэрэг
1	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүх	185	6	31
2	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүх	87	4	22
3	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүх	96	4	24
4	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүх	174	4	44
5	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүх	37	3	12
6	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх	117	4	29
7	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүх	135	3	45
8	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүх	51	4	13
9	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүх	150	5	30
10	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх	1129	14	81
Нийт		2161	51	42

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн ачаалал: Иргэний хэргийн давж заалдах шатны 10 шүүхэд нийт 48 шүүгч ажиллаж байна. Улсын хэмжээнд Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн ачаалал нэг шүүгчид дунджаар 41 хэрэг байна. Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн нэг шүүгчид 102 хэрэг ногдож байгаа нь их ачаалалтайг, Иргэний хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүхэд нэг шүүгч 8 хэрэг шийдвэрлэж байгаа нь ачаалал харьцангуй бага байгааг харуулж байна. /Хүснэгт 8.6/

Хүснэгт 8.6		Шүүгчийн ажлын ачаалал (Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх)		
Д/д	Шүүх	Иргэний хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэрэг
1	Иргэний хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүх	57	5	11
2	Иргэний хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүх	41	3	14
3	Иргэний хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүх	40	4	10
4	Иргэний хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүх	64	4	16
5	Иргэний хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүх	44	3	15
6	Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх	147	4	37
7	Иргэний хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүх	146	4	37

8	Иргэний хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүх	30	4	8
9	Иргэний хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүх	165	5	33
10	Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дүгээр шүүх	1228	12	102
Нийт		1962	48	41